



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААН

## ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр, Мягмар гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-36
<hr/>	
1.Хянан шалгах түр хорооны тайлан, санал, дүгнэлтийг хэлэлцэх	4-36

***Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Хянан шалгах түр хороо /Хилийн боомтуудаар ачаа, тээвэр, нүүрс  
нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа  
хүндрэлийг шалган тогтоох/-ны 06 дугаар сарын 27-ны өдөр  
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл***

Хянан шалгах түр хорооны дарга Г.Ганболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 13 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 69.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 59 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Б.Баттөмөр, С.Бямбацогт, Т.Доржханд.

***Нэг.Хянан шалгах түр хорооны тайлан, санал, дүгнэлтийг хэлэлцэх***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хянан шалгах түр хорооны Хянан шалгагч Н.Адъяацэрэн, М.Батмөнх, шинжээч Р.Онгонцэцэг, Г.Уянгахишиг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, мөн хэлтсийн референт С.Тэгшжаргал, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт С.Хэрлэн, мөн хэлтсийн Хяналт шинжилгээ, үнэлгээний албаны референт Б.Буянзаяа нар байлцав.

Хянан шалгах түр хорооны тайлан, санал, дүгнэлтийг Хянан шалгах түр хорооны дарга Г.Ганболд танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал, Т.Энхтүвшин, Б.Бейсен, С.Ганбаатар, Н.Наранбаатар нарын тавьсан асуултад Түр хорооны дарга Г.Ганболд, шинжээч Г.Уянгахишиг нар хариулж, тайлбар хийв.

Түр хорооноос гарах санал, дүгнэлтийг Түр хорооны дарга Г.Ганболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Хянан шалгах түр хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 14 минут үргэлжилж, 13 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 76.9 хувийн ирцтэйгээр 14 цаг 13 минутад өндөрлөв.

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ТҮР ХОРООНЫ ДАРГА

Г.ГАНБОЛД

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**  
**ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**

П.МЯДАГМАА

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим  
11 цаг 59 минут.

### **ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Ганболд:** Гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгаж байна. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор байгуулагдсан хилийн боомтуудаар ачаа, тээвэр, нүүрс тээвэрлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалган тогтоох, хянан шалгах үүрэг бүхий Түр хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Хянан шалгах хорооны 2023 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа, Ганбаатар, Ганибал, Наранбаатар, Анандбазар, Мөнхбаатар, Энхтүвшин нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна. Өнөөдрийн түр хорооны хурлаар Түр хорооны явцын тайлан хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад асуух асуулт, саналтай гишүүн байна уу? Ганбаатар гишүүний микрофоныг өгье.

**С.Ганбаатар:** Түр хорооны хурлаа энэ боомтоор ачаа тээвэр нүүрс тээвэрлүүлэх болон нүүрсний хэрэг гээд Монголын ард түмэн таньдаг мэддэг болчихсондоо. Ингээд энэ асуудлыг ард иргэдэд нээлттэй мэдээллийг тэртээ тэргүй энэ нүүрсний эзэн болсон ард иргэдэд баялгийн эзэн болсон ард иргэдэд нээлттэй явуулах ёстой. Цаашид ч гэсэндээ байнга нээлттэй явуулж байх

ёстой гэсэн ийм горимын саналыг би гаргаж байна энийг дэмжиж өгөөч ээ.

**Г.Ганболд:** Улсын Их Хурлын дэгийн хуулиар Түр хорооны явцын тайлан хэлэлцэх хурлыг нээлттэйгээр явуулах боломжтой. Хэрэв шаардлагатай гэж үзээд хаалттайгаар явуулья гэх юм бол горимын санал гаргаад хаалттай явж болох юм.

Тэгэхээр бол одоо бол дэгээрээ нээлттэй явж байгаа гэж ойлгож болно. Өөр гишүүн хаалттай явуулах горимын санал гаргахгүй бол шууд нээлттэйгээр явна гэж ойлгож болно. Өөр асуулт саналтай гишүүн байна уу? Байхгүй бол хэлэлцэх асуудлын төлөвлөгөөгөө баталъя.

Хянан шалгагч шинжээчдийг оруулья. Өнөөдрийн хуралдаанд оролцож байгаа шинжээчид хянан шалгагч нарыг танилцуулья.

Түр хорооны хянан шалгагч Нямцэрэнгийн Адыацэрэн, Мөнхжаргалын Батмөнх, түр хорооны шинжээч Раднаа-Очирын Онгонцэцэг, Гончигдоржийн Уянгахушиг нар оролцож байна. Ингээд Түр хорооны хурлаар хэлэлцэх тайланг танилцуулья.

Монгол Улсын Үндсэн хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Их хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.3 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.2, 34.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор Хянан шалгах түр хороог байгуулж, хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэлээ.

Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хороо нь хилийн боомтуудаар ачаа тээвэр, нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл

ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалган тогтоох ажлыг Монгол Улсын Их Хурлын 31 дүгээр тогтоолын хүрээнд дараах чиглэлээр зохион байгууллаа.

Үүнд хилийн боомтуудад очиж нүүрс нэвтрүүлж байгаа ажлыг газар дээр нь танилцах, хил боомтын ажилд оролцож байгаа мэргэжлийн хяналт, гааль, хил хамгаалах, цагдаа, хилийн боомтын үндэсний зөвлөлийн ажлын уялдаа холбоо, мэдээ, мэдээлэл солилцож байгаа явц, Гаалийн хяналтын бүсийн зохион байгуулалт боомтод үйл ажиллагаа явуулж байгаа ААН-ийн үйл ажиллагаа, нүүрсний тээвэр ложистикийн үйл ажиллагаа, бүртгэл хяналт, экспортод гаргаж байгаа нүүрсний гаалийн бүрдүүлэлт, уул уурхайн салбарт төр болон хувийн хэвилийн ААН-үүдийн нүүрс экспортлохтой холбоотой гэрээ эрх зүйн зохицуулалт, тэдгээрийн худалдааны үнэ тарифын талаар хууль тогтоомжийн хэрэгжилт гэсэн энэ сэдвийн хүрээнд явагдсан болно. Түр хорооны бүрэн эрхийн хугацаанд 5 шинжээч, 5 хянан шалгагчийг томилон дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Нийт 6 удаа хуралдаж Хянан шалгах түр хорооны үйл ажиллагаа зохион байгуулалттай холбоотой 10 тогтоолыг баталсан.

2022 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Түр хороо Ховд аймгийн Булган хилийн боомт, Баян-Өлгий аймгийн Цагааннуур чөлөөт бүсэд 2022 оны 11, 12 дугаар сард Өмнөговь аймгийн Гашиунсухайт, Дорноговь аймгийн Ханги боомтын үйл ажиллагаануудтай удаа дараа очиж танилцсан болно. Хянан шалгах түр хорооноос тайлант хугацаанд нийт 77 албан бичгийг холбогдох газруудад хүргүүлж, 45 албан бичиг ирүүлсэн материалтай танилцан нотлох баримт цуглуулах нөхцөл байдалтай газар дээр нь танилцах тэмдэглэл үйлдэх баримт цуглуулсан.

Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны 2023 оны 11 дүгээр тогтоолоор Түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах сонсголын товыг баталж 2023 оны 4 дүгээр сарын 10, 11, 12-ны өдрүүдийн хуралдаанаар хэлэлцэхээр олон нийтэд зарлан бэлтгэл ажлыг хангасан болно. Гэвч сонсгол дуудагдахаар товлосон 100 гаруй этгээдийн 50 орчим хувь нь АТГ болон цагдаагийн байгууллагад нэгэнт шалгуулж гол гэрчүүдийн хувьд таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан нь Түр хорооны сонсголыг зохион байгуулахад хүндрэлтэй нөхцөл бий болсон.

Мөрдөн байцаах ажлын нууцыг хамгаалах үр дүнг дээшлүүлэх шаардлагаар АТГ-аас 2023 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 06/5464 дугаартай албан тоотоор Түр хорооны сонсголыг хойшлуулах хүсэлтийг тавьсан тул сонсгол хийх боломжгүй болсон. Түр хороо дараах 3 асуудлаар сонсголыг зохион байгуулахаар төлөвлөсөн. Нэг хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн дүн нүүрсний бодит асуудлаар. Нүүрсний мэдээллийг АНУ-ын нийгэм эдийн засгийн хөгжлийн асуудал уул уурхайн салбарын бүхий л мэдээллийн тоон өгөгдлийг нэгтгэдэг Си Эс системээс БНХАУ-ын Монгол Улсаас импортлосон нүүрсний тоо хэмжээ БНХАУ-ын Эс икс күүл нүүрсний албан ёсны тоон мэдээлэл Монгол Улсын ГЕГ-ын тоон мэдээллүүдийг ашигласан. Монгол Улсаас БНХАУ руу экспортод гаргаж буй нүүрсний болон БНХАУ-ын Монгол Улсаас импортлож буй чулуун нүүрсний тоо хэмжээг 2008-аас 2022 онд дараах байдлаар гаргалаа.

2008-2022 онд Монгол Улс, БНХАУ-уудын ГЕГ-ын экспорт, импортын мэдээг зэрэгцүүлэн үзэхэд 6.9 сая тонны зөрүүтэй байна. Үүнээс Түр хорооны хяналт шалгалтын хамрах хүрээнд 2018-2022 онд Монгол Улс БНХАУ-уудын ГЕГ-ын экспорт импортын мэдээг зэрэгцүүлэн үзэхэд 3.2 сая тонны зөрөөтэй гэсэн мэдээллүүд

гарсан. Уг мэдээллийг баталгаажуулах зорилгоор Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос Гаалийн ерөнхий газрын даргад Гашуун сухайт боомтод ажиллаж байгаа нүүрс ачих буулгах талбайд 2018-2022 оны хооронд экспортлогдсон нүүрсийг шалгах хүсэлт гаргасны дагуу ажлын хэсэг томилон шалгалтын ажиллагааг зохион байгуулж Эрдэнэс Тавантолгой, Тавантолгой компанийн нүүрс худалдах, худалдан авах 381 гэрээгээр 121.6 сая тонн нүүрс борлуулах гэрээ бүрээр гаалийн талбайд тулгалт хийж шинжилсэн Эрдэнэс Тавантолгой компани 36, Тавантолгой компаниас 10 нийт 46 гэрээгээр 31.8 сая тонн нүүрс худалдан авах гэрээ байгуулж уурхайгаас 16 сая тонн нүүрс буусан байна. Энүүн болор хуяг компанийн гаалийн хяналтын талбайд 4.1 сая тонн нүүрс буусан үүнээс 3.5 сая тонн нүүрс гаалийн бүрдүүлэлт хийж экспортлогдсоноос 0.6 сая буюу 600 мянган тонн нүүрс дутуу гаалийн бүрдүүлэлт хийсэн байна. Ханбогд Инженеринг компанийн гаалийн хяналтын талбайд 1.9 сая тонн нүүрс буусан. Үүнээс 1.4 сая тонн нүүрс гаалийн бүрдүүлэлт хийж 0.5 сая буюу 500 мянган тонн нүүрс гаалийн дутуу бүрдүүлэлт хийгдсэн. Бусад талбайд 8.5 сая тонн нүүрс бууж 10.5 сая тонн нүүрс гаалийн бүрдүүлэлт хийж 2 сая тонн нүүрс эх үүсвэргүй гарсан байна. Энэ тоо баримтыг гаалийн байгууллагын ажлын хэсэг гарган баталгаажуулсан бөгөөд 2 нүүрс нүүрс ачиж буулгах талбайгаас зөвхөн 2 талбайгаас 1.1 сая тонн нүүрс дутааж байгаа нь татвараас зайлсхийсэн. Бусад талбайгаас 2 сая тонн нүүрс илүү бүрдүүлэлт хийж гаргасан нь эх үүсвэргүй уурхайгаас алдагдсан нүүрс гэж ойлгохоор байна.

Шалгалтын хүрээнд БНХАУ-ын нэгэн иргэн гадаадын хөрөнгө оруулалттай Качфлов Энержи компанийг байгуулан Гашуун сухайт боомтод охин компани байгуулан нүүрс ачих буулгах талбайн үйл ажиллагаа эрхэлдэг. Энүүнболор Хуяг компани,

Говийн мөнгөн жолоо компани нүүрс тээврийн үйл ажиллагаа явуулдаг Камилист ложистик компани 59, Качнис компани 126, Төмөр туурай компани 102, Адали инк компани 102, Силвер Титан Интернэшнл компани 128, нийт 517 автомашинаар Эрдэнэс Тавантолгой компанийн ЭТТ 2019 оны 324, 325, 340, 341 ЭТТ 2020 314 504 тоот гэрээний нүүрсийг тээвэрлэдэг байна.

Гаалийн 2022 оны шалгалтаар илэрсэн Гашуун сухайт боомтоор нэвтрэхдээ гаалийн хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгслийн бүртгэлд бүртгэгдээгүй 22664 бичлэг буюу 12189 тээврийн хэрэгслийн бүртгэлээс Качфлов Энержи компанийн охин компанийн 517 автомашины дугаарыг шалгуулаад байна. Уг мэдээллээс харахад гаднын хөрөнгө оруулалт нэрийн доор нэг компани нүүрс ачиж буулгах талбайтай, өөрийн 517 автомашинтай их хэмжээний нүүрсний гэрээнүүдийг ТӨК-уудтай хийж гаалийн байцаагчтай хуйвалдан хоосон машин гаргах нөхцөлийг бүрдүүлсэн. Тухайн өдрийн Гашуунсухайт боомтоор хил нэвтэрсэн автомашины бүртгэлийг хил хамгаалах газар, ГЕГ-ын мэдээллийн сангуудаас гаргуулан авч харьцуулахад ГЕГ-ын гаалийн бүртгэлд хийж хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгсэл мэдээллийн санд бүртгэгдээгүй 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдөр 147, 2021 оны 10 дугаар сарын 9-нд 74, 2021 оны 11 дүгээр сарын 15-нд 71 тээврийн хэрэгсэл бүртгэгдээгүй хилээр нэвтэрсэн. 2021 оны 3 дугаар сарын 1-нд Тавантолгой тээврийн нэгдэл компанийн 8 автомашин нүүрс тээвэрлэж улсын хилээр гарсан боловч гаалийн мэдээллийн санд бүртгэгдээгүй байна.

2.Нүүрсний ангилж шинжлэх лабораторийн дүнгийн зөрөө байгаа нь сайн чанарын нүүрсийг үнэгүйдүүлэх эрсдэл өндөр байна. 2018 оноос хойш 7 сая тонн нүүрсийг чанаргүй буюу эрчим хүчний нүүрс нэрийн доор 9-өөс 18 доллароор борлуулсан нь Монгол Улсад

асар их хохирол учруулсан байх магадлалтай байна. Шалгалтын хүрээнд Тавантолгой компанийн өмнөх дээжид хийсэн шинжилгээний хариуг өөр лабораторид шинжлүүлэхэд зөрөөтэй байсан болно. Дээрх зөрчлүүд олон удаа давтагдан нь гарсан нь дараах шалтгаантай байна гэж үзэж байгаа. ГЕГ-аас өөрийн дотоод хяналт шалгалтын шугамаар АТГ, Цагдаагийн ерөнхий газарт шилжүүлсэн зөрчлийн болон гэмт хэргийн шинжтэй мэдээллүүдийн зүйлчлэлийг нь өөрчилж хэрэгсэхгүй болгодог.

Нүүрсний хулгай хавтгайрч үүний төлөө хариуцлага хүлээдэггүй гэсэн ойлголтыг бий болгоход тухайн үеийн УЕПГ, АТГ, ЦЕГ-ын ажил хариуцсан албан тушаалуудтай холбоотой гэж үзэж байна. Энэ хүрээнд 2013, 2018, 2022 оны гаалийн дотоод шалгалтын дүнгээр илэрсэн зөрчлүүд болон үүнд хэрэг үүсгэгдээд хэрэгсэхгүй болгосон хэргүүдийг тайланд тусгасан байгааг та бүхэнд танилцуулсан болно.

2.Нууцад хамрагдсан гэрээнүүдийн талаар Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 449 дүгээр тогтоолоор улсын нууцлалаас гаргасныг доорх хүснэгтэд дурдсан 9 гэрээ түүнтэй холбоотой материалыг судалж танилцан дүгнэлт гаргасан бөгөөд ҮАБЗ, ЗГХЭГ, Эрдэнэс Тавантолгой компанийн эрх бүхий албан тушаалтнуудаас үүнээс өөр улсын нууцлалд үлдээсэн гэрээ байхгүй тухай мэдээллийг иш үндэс болгож, гэрээнүүдэд шинжилгээ хийж, хэрэгжилтийг тооцон тооцон гаргалаа. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 449 дүгээр тогтоолоор нууцаас гаргаж Улсын Их Хурлын Түр хороонд шилжүүлсэн 9 гэрээнээс Тавантолгой Гашуун сухайт чиглэлийн төмөр замын төсөлтэй холбоотой 2, Тавантолгой Зүүнбаян чиглэлийн төмөр зам төсөлтэй холбоотой 2, Богд Хаан төмөр зам төсөлтэй холбоотой 3, усны болон далд уурхайн төслийн тус бүр нэг гэрээ байна.

Шалгалтын явцад БНХАУ-ын Чалко болон Норико компанитай холбоотой 2 гэрээг ил болгож нийтэд дэлгэх боломжгүй байна. Энэ нь гэрээг хийхдээ аль нэг талын зөвшөөрөлгүйгээр гэрээг ил болговол их хэмжээний торгууль төлөх заалтыг тусгасан нь хүндрэл учруулж байна.

Тавантолгой-Зүүнбаян төмөр замын төсөлтэй холбогдуулан уг төмөр зам нь Монгол Улсын стандартаар 3 дугаар зэргийн зам бөгөөд гол замын урт нь 416.1 км, дэлгэмэл урт нь 486.6 км, Төслийн нийт өртөг 1 их наяд 392.2 тэрбум төгрөг буюу 488.5 сая долларыг Эрдэнэс Тавантолгой компаниас мөнгөн хөрөнгөөр шилжүүлсэн нь компанийн санхүүгийн байдал болон 1072 хувьцааны ноогдол ашиг хуваарилах боломжид сөргөөр нөлөөлсөн байна.

Төслийн бүтээн байгуулалтын ажлыг Монголын төмөр зам компани, Зэвсэгт хүчний жанжин штаб, Улаанбаатар төмөр зам, хувь нийлүүлсэн байгууллагууд, ерөнхий гүйцэтгэлээр ажиллаж, нийт 200 орчим компани, байгууллага, хувь хүн туслан гүйцэтгэхээр ажилласан байна. Төслийн дүнг ерөнхий гүйцэтгэлээр харуулсан хүснэгтийг та бүхэнд тараасан. Уг төсөлтэй холбогдуулан Шинэ төмөр зам төслийн хүрээнд 2011 онд Макензи компанийн боловсруулсан ТЭЗҮ-ийг Тавантолгой Сайншанд хэсэгт өөрчлөлт оруулан үндсэн суурь баримт бичиг болгон ашигласан.

Өөрөөр хэлбэл Тавантолгой Зүүнбаян төмөр замд тухайлан хийгдсэн ТЭЗҮ үгүй ажлыг эхэлсэн. Зураг төсөв боловсруулагдан магадлалаар батлагдсаны дараа гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж бүтээн байгуулалтын ажил хийгдэх ёстой байтал зураг төсөлгүйгээр маш олон туслан гүйцэтгэгчийн ажил явагдсан байна.

Доод бүтцийн ажил гүйцэтгэсэн ихэнх компаниудын төмөр зам барих



тусгай зөвшөөрлийг нэгэнт ажил эхэлсэн хойно нь нөхөж олгосон байна. Өөрөөр хэлбэл ЗХЖШ-ын туслан гүйцэтгэгч нарт тусгай зөвшөөрөл олгосон байдлыг Зам, тээврийн яамнаас нарийвчлан мэдээлэл гаргуулсан болно. Туслан гүйцэтгэгчийг сонгох тухай ажлын гүйцэтгэх гэрээний үнийг тогтооходоо Зам, тээврийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 315 дугаар тушаалаар батлагдсан Зэвсэгт хүчний жанжин штабын даргаар ахлуулсан дэд ажлын хэсгийн зөвлөмжөөр шийдвэрлэж байсан байна.

Гэрээний үнэ бодитой эсэх мөн туслан гүйцэтгэгчийг ямар зарчмаар сонгон шалгаруулж байсныг гэрээ тус бүрээр нарийвчлан шалгаж хамаарлуудыг тогтоохоор ажилласан. Доод бүтцийн ажлын ерөнхий гүйцэтгэгч нь ЗХЖШ-ын 81 туслан гүйцэтгэгчийн 14 ажлыг Зэвсэгт хүчний ангиуд гүйцэтгэсэн нь олон нийтэд сурталчлан ойлгуулсан төмөр зам тус төмөр замыг цэргийн ангиудаар бариулсан гэж үзэх үндэслэлгүй гэж үзэж байна. Зэвсэгт хүчний ангиуд Зүүнбаян төмөр замын нийт бүтээн байгуулалтын ажлын 7 орчим хувийг л гүйцэтгэсэн нь зэвсэгт хүчнээр хийлгэх зорилгоор нууцад авсан боловч бодит байдал дээр хувийн хэвшилүүдтэй шууд гэрээ байгуулах нөхцөлийг бүрдүүлсэн гэж үзэж байна.

Хэдийгээр нийт ажлын зохион байгуулалтын хувьд олон хэсэгт хууль журам зөрчигдөн явагдсан ч төмөр замын нийт өртгийн хувьд Тавантолгой-Гашиун Сухайт төмөр замын бүтээн байгуулалтаас даруй 2-оос 2.3 дахин бага байна. Улаанбаатар Төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэгийн төслийн нэгж туслан гүйцэтгэгч нарыг шалгаруулахдаа 3-аас дээш компанид шалгаруулалтад оролцох урилга хүргүүлж харьцуулалтын арга сонгон Дэд ажлын хэсэгт саналаа хүргүүлж ажилласан нь Сайшаалтай. Харин төслийн нэгжийн сонгон шалгаруулсан компанийг туслан гүйцэтгэгчээр сонгож байсан эсэх дээр

ажлын дэд хэсгийн шийдвэрийг цаашид нягтлан шалгах шаардлагууд үүсэж байна. Уг төслийг гүйцэтгэхэд шаардлагатай дал орчим тэрбум төгрөгийн машин тоног төхөөрөмжийн хэрэгслийг шууд худалдан аван төсөлд ашигласан ч цаашид хэрхэн ашиглах нь тодорхойгүй. Ажлын хэсгийн хуралдаанууд тухайн үеийн Монгол Улсын Ерөнхийлөгч Баттулгын албан өрөөнд хуралдаж шийдвэр гаргадаг байсан нь протоколуудаас харагдаж байна. Төслийг гүйцэтгэсэн ЗХЖШ, УБТЗ хувь нийлүүлсэн нийгэмлэгүүд нь нэмэгдсэн өртгийн албан татвар төлдөггүй байсан нь туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд хүндрэл учруулсан.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг яаран барьсан нь эдийн засгийн хувьд ач холбогдол бага байгаа нь ашиглалтад орсноос хойших 2 жилд тээвэрлэлт хийгдээгүйгээс харагдаж байна. УБТЗ-ын ачаалал их 100 хувь ачаалалтай байгаа замд хажуугаас хөндлөн замаар холбон нүүрс зөөх нь боломж бага байгааг харуулж байгаа юм.

2.Богд хаан төмөр замын төсөл дээр:

Тавантолгойн төмөр зам компанийн захиалгаар Урбан девелопмент Консалтинг групп компаниас боловсруулж зам тээврийн хөгжлийн төв төрийн өмчит үйлдвэрийн газрын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 243/2021 магадлалын ерөнхий дүгнэлтээр магадлагдсан Богд Хаан Төмөр замын ЗТХЯ-ны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн 2022 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 1 дүгээр шийдвэрээр дэмжсэн байна.

2022 оны 5 дугаар сарын 22-ны өдөр техник эдийн засгийн үндэслэлд нэмэлт, өөрчлөлт орж мөн эрх бүхий байгууллагууд баталгаажуулсан байна. Төслийн нийт өртөг нь 1.4 тэрбум амдоллар, суурь бүтцийн нийт 670.2 сая

амдолларын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр УБТЗ хувь нийлүүлсэн нийгэмлэг, мөн Зэвсэгт хүчний жанжин штаб, харин нийт 734.6 сая амдолларын төсөвт өртөгтэй туннел, сткадан гүүрний бүтээн байгуулалтын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр Бодь интернэйшнл компани сонгогдож санхүүжилтийг Эрдэнэс Тавантолгой компани хийхээр гэрээнүүдэд тусгачихсан байна.

Бодь интернэйшнл компанийн санхүүжилтийг нүүрсээр санхүүжүүлэх

ЭТТ 2024/488 ВІВВRСОНТ 003 дугаартай гэрээг ажил гүйцэтгэгч болон Эрдэнэс Тавантолгой компанийн хооронд 2022 оны 6 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан байна. Монгол Улсын Засгийн газраас төслийн ажлыг түр хугацаанд зогсоосон хэдий ч 2023 оны эхний улирлын байдлаар Эрдэнэс Тавантолгой компаниас Бодь интернэйшнл компани нь 26.3 сая амдолларын нүүрсийг БНХАУ-ын нэр бүхий 11 худалдан авагчид нийлүүлсэн байна.

Санхүүжилтийн график хуваарийг та бүхэнд тараасан тайлан дээр дэлгэрэнгүй тусгасан байна. Тавантолгой-Гашуун сухайт төмөр замын төсөл Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замыг анх Ухаа худаг-Гашуун сухайт чиглэлээр барих эрхийг Энержи Ресурс Рейл компани барих ашиглах шилжүүлэх концессын гэрээнд 30 жилийн дараа Монгол Улсын Засгийн газарт тодорхой хувийг буцаан шилжүүлэх нөхцөлтэйгөөр 2008 оны 6 дугаар сарын 18-нд тус компанид концессын эрх өгсөн. Төслийн ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулах ажилд АЕСОМ Asia олон улсын байгууллагыг 2013 онд Энержи Ресурс Рейл компанийн зүгээс гүйцэтгэгчээр сонгон авч ажилласан бөгөөд зөвлөх үйлчилгээний хүрээнд гарсан төслийг нийт хөрөнгө оруулалт 1 тэрбум 68 сая доллар. 1 тэрбум 68 сая долларыг тооцоходоо хөдлөх бүрэлдэхүүн, дохиолол холбооноос бусад бүх зардлын

мэдээллийг Энержи Ресурс Рейл компаниас хүлээн авсан бөгөөд АЕСОМ-ын зүгээс уг асуудалд хувийн хэвшлийн байгууллага зардлаа өндөр өсгөж бичих үндэслэлгүй гэж үзэж байна хэмээн тайлбарласан авч Энержи Ресурс Рейл компанийн хийж бүтээсэн ажлынхаа тодорхой хувийг ирээдүйд Монгол Улсын Засгийн газарт буцаан шилжүүлэх үүрэгтэй тул ашиг орлогоо нэмэгдүүлэх зорилгоор төрд өндөр үнээр нийлүүлэх сонирхол байх магадлалтай тул өртгөө аль болох өндрөөр тусгах ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэж байна. Энэ утгаараа ТЭЗҮ-д тусгасан хөрөнгө оруулалтын тооцоонууд нь зах зээлийн бодит байдалтай нийцэхгүй байх үндэслэлтэй юм.

Дээрх үндэслэл нь шинжээчийн нотлох баримтыг судлах явцад баримтаар тогтоогдсон. Жишээ дурдвал 2013 оны 10 дугаар сарын тооцоогоор захиргааны барилгын ажлын метр квадратыг 1200 ам.доллар магадалиггүй зардалтайгаа нийлээд 1380 амдоллар үйлдвэрлэлийн барилгын ажлын метр квадратыг 1850 доллар, магадалиггүй зардалтайгаа нийлээд 2127 доллар гэж тусгажээ. Гэтэл Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 336 дугаар тогтоолоор баталсан барилгын нэгж талбайн төсөвт өртөг мөн үүнд хамаарах үнийн индекс итгэлцүүр тухайн үеийн ханиш зэрэг тооцооллыг оруулан бодож үзэхэд захиргааны барилгын ажлын метр квадрат нь 822 амдоллар үйлдвэрлэлийн барилгын ажлын метр квадрат нь 989 амдоллар байсан байна тухайн үеийн индексээ бодвол. Аливаа бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэхэд батлагдсан ТЭЗҮ дээр үндэслэн ажлын нарийвчилсан зураг төслийг тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, холбогдох яам, хяналт шалгалтын байгууллагаар баталгаажуулахын үндсэн дээр хийгдэх ажил болон нийт ажлын төсөв гардаг бөгөөд энэхүү төслийг хэрэгжүүлэхэд зөвхөн ТЭЗҮ-д тусгагдсан хөрөнгө

оруулалтын дүнг ашиглан явсан нь энэ нь нийт төслийн шаардлагатай хөрөнгө оруулалт, хийдэл үүсэх нөхцөлийг бүрдүүлжээ.

Мөн цаг хугацаа, санхүүгийн тооцоолол, техник технологийн шийдлийн хувьд хоцрогдсон 2013 оны уг АЕСОМ ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулах тодотгол хийх талаар Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 242 дугаар тогтоол Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 176 дугаар захирамж, Зам, тээврийн хөгжлийн сайд Эрдэнэс Тавантолгойн болон Тавантолгой төмөр зам компаниудын ТҮЗ-ийн тогтоол зэрэг тус тус тушаал шийдвэрүүдийг хэрэгжүүлээгүйн улмаас зөвхөн дээр дурдсан томоохон зөрчлөөс гадна техник технологийн шийдлийн хоцрогдол, холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлт Монгол Улсын нүүрс олборлолтын хэмжээ, хэтийн төлөв гарсан өөрчлөлт, олон улсын байгаль орчны стандарт түүнтэй уялдан техник технологийн өөрчлөлт дэвшил зэрэг олон асуудлыг дахин харж үзэлгүй төслийг хэрэгжүүлсэн нь олон эрсдэлт асуудлуудыг бий болгоход хүргэсэн байна.

276.4 сая ам.долларын гүйцэтгэлийн талаар:

Төслийн бүтээн байгуулалтын ажлыг Энержи Ресурс Рэйл Компани хэрэгжүүлж байх явцад Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр түр хэрэгжүүлэхээр болж Монголын төмөр зам компанид төмөр зам барих эрхийг өмнө нь хийгдсэн ажлын хамтаар шилжүүлэн өгсөн. Энержи Ресурс Рэйл компанийн хийсэн ажилд нийт 76.4 сая амдолларын нөхөн олговрыг олгосон бөгөөд Хөгжлийн банкны 200 сая долларын санхүүжилтээр Монголын төмөр зам төрийн өмчит компани үргэлжлүүлэн гүйцэтгэсэн байна. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 242 дугаар тогтоолоор Тавантолгой төмөр зам компанийг байгуулж тусгай зөвшөөрлийг шилжүүлж улмаар Монгол

Улсын Засгийн газрын 2019 оны 304 тоот тогтоолоор Тавантолгой төмөр зам компанийн нийт хувьцааны 34 хувийг Монголын төмөр зам компанид шилжүүлэх зэрэг шийдвэрийг үндэслэн тус компанийн хөрөнгө оруулалтад шинэ төмөр зам төслийн хүрээнд 2013 оны 4 дүгээр сарын 1-ний 2019 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд 4 дүгээр сарын 1-нээс 2019 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд Монгол төмөр зам ТӨК-ын оруулсан 276.4 сая ам.долларын хөрөнгийг баланст шилжүүлэх шийдвэрийг тухайн компаниудын эрх бүхий байгууллага төр засгийн холбогдох байгууллагуудад гаргасан байна. Балансаас баланст шилжүүлэх хөрөнгийн дүнг баталгаажуулах ажлыг Монголын төмөр зам ТӨК-ийн захиалгаар аудитын Грант Торнтон аудит компани 2017-2019 онуудад хийж гүйцэтгэсэн дээрх 276.4 сая долларын дүнг баталгаажуулсан.

Илэрсэн зөрчлүүд:

Монголын төмөр зам компаниас Тавантолгой Төмөр зам компанид хөрөнгийг балансаас балансаар шилжүүлэх явцад хөрөнгийн үнэлгээ бүртгэлийн ард алдаа гарсан байна. 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Тавантолгой төмөр зам компаниас Монголын төмөр зам ХК-д явуулсан албан бичигт эд хөрөнгө шилжүүлэх ажил удааширалтай байгааг дурдан хөрөнгө тооллогын явцад дутсан хөрөнгийн мэдээллийг хүргүүлсэн байдал.

Тавантолгой төмөр зам компаниас 2021 оны 8 дугаар сарын 12 болон 11 дүгээр сарын 8-ны өдрүүдэд Монголын төмөр зам компанид явуулсан албан бичигт дурдсанаар 2020 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газарт шалгалт хийж дээрх дуусаагүй үйлдвэрлэлийг дэлгэрэнгүйгээр бүртгэх зөвлөмж өгсөн байна.

Төслийн ажлыг үргэлжлэн явагдахад шилжүүлсэн зарим хөрөнгийг ашиглах боломжгүй болсон мөн зарим хөрөнгийн ашиглалт хангалтгүй байсан байж болзошгүй байна. Хөрөнгийг балансаас баланст шилжүүлэхэд нийт 11 сая ам.доллар болон 746.6 сая төгрөгийн зөвлөх үйлчилгээний 7 ажлын тайлан үр дүнг Монголын төмөр зам компаниас Тавантолгой төмөр зам компанид хүлээлгэн өгөөгүй нь хөрөнгө хүлээлцэх актаар нотлогдсон. Уг төсөлд ТЭЗҮ-д нийтдээ зөвлөх үйлчилгээний 1 сая доллар л зарцуулахаар төлөвлөсөн бол 11 сая долларыг санхүүгийн болон хуулийн зөвлөх үйлчилгээ нэрийн доор аж ахуйн нэгжүүдэд өгсөн. Энэнээс буцаагаад уг ААН-үүдээр санхүүгийн болон хуулийн ямар зөвлөх үйлчилгээ авсан нь тодорхойгүй акт үйлдэгдээгүйгээр ТЭЗҮ-д тусгасан зөвлөх үйлчилгээний зардлыг 10 дахин ихээр тооцсон байгаа юм. Энэ Гранд Тронтинг компанийн гаргасан тодорхойлолтыг үндэслээд 276.4 сая долларын буюу одоогийн үнэлгээгээр 1 их наяд төгрөгөөр 206 км бид нарын өмнө ярьж байсан далан шорооны ажлыг авсан нь өнөөдрийн үнийн ханшаар бол 1 км-ийг нь 5 тэрбум төгрөгөөр 80 хувийн гүйцэтгэлтэй зөвхөн далангийг 1 км-ийг 5 орчим тэрбум төгрөгөөр үнэлж авсан нь уг төсөл илүү өндөр өртөгтэй болох ийм эрсдэлүүдийг гүйцэтгэсэн гэж үзэж байгаа юм.

276.76 сая доллароор хүлээж авснаар цаашид энэ ажлыг гүйцэтгүүлэх ажлыг Бодь интернэйшнл компаниар гүйцэтгүүлсэн. Хэдийгээр Бодь интернэйшнл компаниар гүйцэтгүүлэх санамж бичгийг 2019 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр буюу УАБЗ-өөр оруулж Засгийн газраас энэ нууцад авах шийдвэр гарахаас өмнө Бодь компанитай санамж бичгийг байгуулсан байсан. Энэ үндэслэлээр Бодь компанийн давуу байдал олгосон сонгон шалгаруулалт хийлгүйгээр уг компанитай гэрээ хийсэн гэсэн дүгнэлтүүдийг шинжээчид гаргасан байгаа юм. Гэрээг хийснээр маш

олон эрсдэлүүд гарах ийм үндэслэлүүдийг бий болгосон.

Нэгдүгээрт нь ТЭЗҮ-д нийт 18 зүтгүүрийг худалдан авахаар тооцсон бол одоогийн гэрээгээр 16 зүтгүүр буюу 2 зүтгүүрээр дутуу гэрээ хийгдсэн. Төмөр замын хамгийн чухал бүрэлдэхүүн хэсгүүдийн нэг болох зүтгүүрийг сонгохдоо сонгон шалгаруулалтаар худалдан авах зарчмыг баримтлаагүй, хамгийн сайн сонголтыг хийж чадаагүй гэж шинжээчид үзэж байгаа юм. Өмнө нь олон улсад борлуулалт хийгдэж байгаагүй өндөр эрсдэлтэй моделийг анх удаа энэ төсөл дээр авч байгаа нь шинжээчдийн дүгнэлтээр тогтоогдож байгаа юм. Тавантолгой төмөр зам компанийн зүгээс зүтгүүрийн хамгийн сайн сонголтын хувьд шинжээчдийн хийсэн бие даасан судалгаа болон сүүлд нотлох баримт цуглуулах хүрээнд нэмэлтээр авсан Домэйны ТЭЗҮ-тэй танилцах үед ТЭЗҮ дотор хийгдсэн зүтгүүрийн сонголтын талаар судалгааны тайлан 2 яг адил таарч нэг үйлдвэрийн нэг моделийг санал болгосон байна.

ТЭЗҮ-д зүтгүүрийн үнийг томсгосон байдлаар нэг ширхгийг 4 сая 380 мянган амдоллороор гэж тусгасан бол харин Бодь интернэйшнл компанийн төсөлд ханган нийлүүлэхээр сонгогдсон зүтгүүрийн марк, үнийн судалгаагаар судалгаа хийж үзэхэд тухайн сонгогдсон моделийн үнийн мэдээлэл олдоогүй боловч цувралын зүтгүүрүүд нь 2.5 орчим сая долларын өртөгтэй байгаа нь мэдээллийг [www.american.com](http://www.american.com) веб сайтаас авсан мэдээллээс харахад үнийг хэт өндөр тусгасан гэсэн дүгнэлтийг хийхэд хүргэж байгаа юм. Төмөр зам Монголын стандартаар 60-аас 75 кг-ын масстай зам төмрийг 1 дүгээр зэргийн төмөр замд шаарддаг бөгөөд энэхүү төсөлд ашиглагдах зам тээврийн сонголтыг ТЭЗҮ-д А65 хувилбараар А75 гэж сонгосон байгаа.

Төслийн нийт төсөв хүрэх аваас А75-ыг шууд суурилуулж болох ба ингэснээр А60 тавтай харьцуулбал ашиглалтын хугацааг нэмэгдүүлнэ гэж тусгажээ. Харин материалын хомсдол үүсэх үүднээс Монголын А төрлийн төмөр замын хувьд олон улсын стандартын UIC 60 A1 хувилбар болгож ашиглаж болох ч Монголын стандард нийцдэггүй байна гэж тусгасан бол энэ Бодь интернэйшнл компани дэр төмрийг сонгохдоо 60 кг-ын буюу төсөлд тусгасан төмөр замаас 60 кг-аар гэдэг нь хамгийн багадаа 5 кг-аар бага ийм дэр төмрийг сонгосон гэсэн дүгнэлтийг гаргасан байгаа юм.

Дохиолол холбоо ТЭЗҮ-д Австрали болон өөр өндөр үнэтэй зах зээлээс хүний нөөц болон дохиолол холбооны системийг суурилуулахаар хөрөнгө оруулалтыг тооцож тусгасан боловч Тавантолгой Гашиун сухайт чиглэлийн төмөр замын төсөлд Хятадын дохиолол холбооны системийг суурилуулсан. Мэдээж Бодь Интернэйшнл компани нь захиалагчийн шаардлагын дагуу хамгийн эдийн засгийн хэмнэлттэй өөрт ашигтай хувилбарыг сонгон ажиллах нь тодорхой ч төсвийн хөрөнгө оруулалттай худалдан авалтын хувьд төрийн эрх бүхий байгууллага болон захиалагч талд хамгийн хэмнэлттэй хувилбарыг тооцож захиалагчийн шаардлага тавьж авах ёстой байсныг хэрэгжүүлээгүй байна. ТЭЗҮ-д тусгагдсан зарим хөрөнгө оруулалт жишээ нь хүүгийн зардалд 120 сая долларыг банкны төлбөрт 1.1 сая доллар, санхүүгийн хяналт шалгалтад 1 сая доллар зэрэг төрд шилжигдсэнээс хойш хийгдэх шаардлагагүй болсон ажлуудад тусгасан хөрөнгө оруулалт болох 200 гаран сая ам.долларын ажил хөрөнгө оруулалтын талаар Бодь интернэйшнл компаниас тодруулахад ТЭЗҮ-д тусгагдаагүй нэмэлт ажлуудын хөрөнгө оруулалт руу орсон гэж тайлбарласан ч уг нэмэлт ажлуудын нийт хөрөнгө оруулалт нь 54.7 сая доллар бөгөөд дэлгэрэнгүй тайлбар мэдээлэл өгөөгүй болно.

Нэг ёсондоо ТЭЗҮ тусгагдсан зардлаас 200 сая долларыг хэрэгжүүлээгүй гэж ойлгож болно. ТЭЗҮ нь зөвхөн англи хэл дээр боловсруулсан бөгөөд Монгол хэл рүү хөрвүүлэх ажлыг захиалагч, гүйцэтгэгч, санхүүжүүлэгч, хянан шалгах эрх бүхий аль ч байгууллага хэрэгжүүлээгүй бөгөөд энэ төслийг хэрэгжүүлэх тал хэрэгжүүлэгч талууд мэргэжлийн чиг үүргийн дагуу танилцах, судлах, засаж залруулах бололцоог олгоогүй маш том зөрчлийг үүсгэжээ. Өнөөдрийг хүртэл энэ АЕСОМ-ын ТЭЗҮ Монгол хэл дээр орчуулагдаагүй төрийн нууц давсан гэдэг агуулгаараа гүйцэтгэж байгаа Монголын талаас хяналт тавих компаниуд Монгол хэл дээр орчуулаагүй учраас энийг нэг бүрчлэн нягтлах боломж байгаагүй гэж ингэж ойлгож болно. Төслийг хэрэгжүүлэх явцад нэмэлтээр БНСУ-ын домён гэж компаниар нэмэлт ТЭЗҮ хийлгэсэн. 213 сая долларын өртөг бүхий ТЭЗҮ-г хийлгэсэн байгаа. ТЭЗҮ-д суурьшлын бүсийг нийтдээ 1300 айлын орон сууцыг багтаасан 2 суурьшлын бүсийг Цогтцэций суманд мянган айлын орон сууцын хотхон, Гашиун сухайт өртөөд 300 айлын орон сууцын хотхонд тус тус барихаар 42 сая долларын төсөв нэмэлт ТЭЗҮ тусгасан. Гэвч уг төслийг хэрэгжүүлэхгүйгээр 1300 айлын орон сууцыг барилгүй шууд уг ажлыг хийх хөрөнгийг нүүрс буулгах талбай болгон өөрчилсөн. Уг нь бол энэ төслийн хүрээнд 1400 орчим ажилтан төмөр замын ажилтнуудыг ажиллана гэж тооцоолж Зүүнбаян болон Гашиунсухайт дээр суурьшлын бүс барьж тэнд ажиллах хүмүүсийг орон сууцжуулах ийм том төслийг тусгасан байсан боловч 2 талын санаачилгаар шууд өөрчлөөд Нүүрс буулгах талбай болгон өөрчилсөн байгаа юм. Эдгээр томоохон зөрчлүүд бий болсон.

Санхүүжилтийн гэрээтэй холбоотой:

2019 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн Эрдэнэс Тавантолгой компанийн ТУЗ-ийн хуралд 3 талт санхүүжилтийн гэрээг Бодь интернэйшнл компанитай байгуулах эрхийг Гүйцэтгэх захирал Б.Ганхуягт олгох асуудал.

Сонгон шалгаруулалтын процесс тодорхойгүй техник эдийн засгийн хөрөнгө оруулалт тодорхойгүй, тодотгол хийх шаардлагатайн улмаас дэмжигдээгүй ТУЗ-өөр. Эрдэнэс Тавантолгой компанийн ТУЗ-ийн 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хурлын удирдамжид Засгийн газрын 2019 оны 304 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Тавантолгой-Гацуун сухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлыг санхүүжүүлэхээр холбогдох хууль тогтоомж эрх бүхий байгууллагын шийдвэр тооцоо судалгаанд нийцсэн санхүүжилтийн хэлцэл хийх эрхийг гүйцэтгэх захирал Ганхуягт зөвшөөрөх гэж заасны дагуу тухайн өдөр хуралдаж өмнө нь хөндөгдсөн асуудлууд дахин хэлэлцэгдэлгүй гэрээ хийх эрхийг гүйцэтгэхлээр шууд олгосон байна.

Тавантолгой-Гацуун сухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл худалдан авалтын ажлын санхүүжилтийн гэрээний Бодь интернэйшнл компани нь Тавантолгой-Гацуун сухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтыг дуусахад шаардагдах мөнгөн хөргийг олон улсын банк санхүүгийн байгууллага болон бусад талуудаас хөрөнгө босгох замаар санхүүжүүлнэ гэж тусгасан. Гүйцэтгэгчийн хөрөнгө босгох үйл ажиллагааг санхүүжилтийн хуваарь, Тавантолгой Гацуун сухайт чиглэлтийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээнд заасан хуваарийн дагуу хэвийн үргэлжлүүлэх шаардлагыг хангасан байна гэж тус тус заасан.

Бодь интернэйшнл компаниас ирүүлсэн мэдээлэлд санхүүгийг эх үүсвэрийн тухайд нэрлэсэн худалдан авагчийн урьдчилсан санхүүжилт, гадаад худалдааны санхүүжилт, дотоодын банк санхүүгийн байгууллага ААН-ийн зээлийн хэлбэрээр төслийн санхүүжилтийн менежментийг хэрэгжүүлсэн гэжээ. Мөн санхүүжилтийн хүрээнд Эрдэнэс Тавантолгой компани болон Засгийн газраас ямар нэгэн баталгаа шаардлагагүйгээр төслийн санхүүжилтийг босгон ажилласан тухай дурдсан байна.

Олон улсын банк санхүүгийн байгууллага болон бусад талаас хөрөнгө босгосон талаар:

Дээр дурдсаны дагуу 3 хэлбэрээр босгосон Санхүүжилтийн хувьд худалдан авагчид буюу нүүрс худалдан авагчаас урьдчилсан санхүүжилт авах тухай гэрээ мөн БНХАУ-ын худалдан авагчид тухайн улсын банкнаас зээл авч санхүүжих хэлбэртэй худалдааны санхүүжилтийн гэрээнүүдийг жишээ болгон Бодь интернэйшнл компаниас ирүүлсэн 3 дахь хэлбэр буюу дотоодын банк ААН-ийн тооцооны санхүүжилт бага дүнтэй буюу 30 сая доллар байна. Ерөнхий гүйцэтгэгч Бодь Интернэйшнл компани нь Эрдэнэс Тавантолгой компаниас нүүрс худалдан авч цааш борлуулдаг. Хятадын худалдан авагчидтай нүүрсний борлуулалт урьдчилгаа хэлбэрийн хэлцлийг хийх замаар үндсэн санхүүжилтийг босгосон байна. Олон улсын банк санхүүгийн байгууллагаас санхүүжилт босгосныг батлах баримт ирүүлээгүй бөгөөд төсөл эхэлснээс хойш өдийг хүртэл Бодь интернэйшнл компаниас ирүүлсэн мэдээллээр гүйцэтгэсэн ажлын дүн 935.6 сая ам.доллар үүнээс Тавантолгой төмөр зам компаниас хүлээн авсан ажлын дүн 575.4 сая амдоллар байна. Харин Эрдэнэс Тавантолгой компани 2023 оны эхний улирлын байдлаар бэлэн мөнгөөр 110 сая ам.доллар. Нүүрсээр 700.1 сая ам.доллар. Нийт 810.1 сая ам.долларын

санхүүжилтийг хийгээд байна. Санхүүжилтийн гэрээ байгуулснаас хойш төслийн эхэн үед Эрдэнэс Тавантолгой компани нүүрсээр 90 сая ам.доллар буюу мөн бэлэн мөнгө хэлбэрээр 110 сая ам.олларын санхүүжилтийг хийсэн ба сар бүр нүүрс нийлүүлэх санхүүжилтийг тасалдуулалгүй хийж ирсэн нь уг төслийг санхүүжүүлэхэд заавалчгүй төмөр замын тусгай зөвшөөрөлгүй, санхүүжилтийн бодит схемгүй, гурав дахь этгээдийг татан оролцуулах шаардлага байсан эсэх, цаашид нүүрс борлуулах гэрээндээ 13 хувийн хөнгөлөлт үзүүлж орлогоо алдах шаардлагагүйгээр шууд гүйцэтгэлээр нь санхүүжилт хийж явах ийм боломжууд байсан юм. Энэ бүх гэрээндээ Чалко болон Норинкогийн компаниудтай хийж байсан гэрээтэй адилаар бүх нүүрсээ 13 хувийн хөнгөлөлттэйгээр Бодь компанид өгсөн нь Монгол Улсын хувьд мөн Эрдэнэс Тавантолгой компанийн ноогдол ашиг тараахад Эрдэнэс Тавантолгой компанийн хувьд бол өндөр эрсдэл учирсан гэж ингэж дүгнэж болохоор байгаа юм.

Та бүхэнд тараасан учраас зүгээр чуулган дээр бол маш товчхон танилцуулна. Түр хорооны тайлан учраас би бас нэлээн дэлгэрэнгүй танилцуулаад явъя гэж ингэж бодож байгаа юм.

Энэ бүхнээс харахад бол Бодь интернэйшнл компанид тусгай зөвшөөрөлгүй байхад нь гэрээ хийсэн. Гэрээ хийгдсэнээс хойш тусгай зөвшөөрөл олгосон. Тухайн компани нь гэрээ хийх жилээ санхүүгийн чадавхтай гэж үзэхээргүй байсан. Та бүхэн энэ хүснэгтээр харж байгаа байх. 2017 онд Бодь интернэйшнл компани бол 115 сая төгрөгийн ашигтай компани байсан. 2018 онд 3.2 тэрбум төгрөгийн алдагдалтай компани байсан. 2019 онд 24.2 тэрбум төгрөгийн алдагдалтай байсан бол төслийг хэрэгжүүлж эхэлснээс хойш 2020 онд Монгол Улсын татварын байгууллагад гаргасан тайлангаар 133.6 тэрбум төгрөгийн,

2021 онд 140.1 тэрбум төгрөгийн ашигтай компани болсон нь энэ санхүүжилтээс харагдаж байгаа юм.

Эсрэгээрээ Тавантолгой компанийн санхүүгийн үзүүлэлтүүд өмнөх жилүүдэд өндөр ашигтай байсан бол тухайн жилүүдэд санхүүжилт эрс багассан нь энэ томоохон төслүүд дээр зайлиггүй гаднын хөндлөнгийн аудитын байгууллагууд оруулах ийм зайлиггүй байгааг харуулж байгаа юм.

Гуравт нь төрийн болон төрийн өмчийн оролцоотой компаниудын худалдан авалтын үнийн дүн зах зээлийн үнээс хэт өндөр, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд гүйцэтгэх удирдлагын хамаарал бүхий хүмүүс сонгон шалгаруулалтад ихээр нөлөөлж байсан нь шалгалтын дүнгээс тогтоогдож байгаа юм. Эрдэнэс Тавантолгой компани 2018-2022 оны хооронд дотоодын худалдан авалтын 9.8 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий 665 тендерийг зарлан хэрэгжүүлсэн байна. Энэ нь Монгол Улсын жилийн хөрөнгө оруулалтаас давсан ийм томоохон худалдан авалтуудыг ТӨК-ууд хийж байсан гэдэг нь харагдаж байгаа юм. Уг худалдан авалтуудаас шинжээчдийн дүгнэлтээр анхаарал татсан зарим худалдан авалтуудыг танилцуулъя.

Өвөрмонгол Хуа Еэ Аж үйлдвэр компани болон Өвөр Монгол Хуа Еэ Барилга, машин механизм компанийн хамтарсан Хуа Еэ түншлэлтэй байгуулсан Эрдэнэс Тавантолгой компанийн 2022 оны 573 дугаар бүхий уул уурхай авто самосвал техник хэрэгсэл худалдан авах 881664733800 төгрөгийн гэрээ. Зөвхөн нэг компанитай бараг их наяд орчим төгрөгийн гэрээ байгуулсан. Уг техник шинжээчдийн дүгнэлтээр болон Тавантолгой компанийн хүлээн авах байгууллагуудын дүгнэлтээр нийлүүлэгдэх техникүүд дээр тайлангаар 13 төрлийн зөрчил илэрч хүлээн авах боломжгүй болсон. Энэ асар өндөр үнийн дүнтэй техник нь орж ирснийхээ дараа

марк дугаар нь тодорхойгүй зарим техникүүдийн мот цаг нь илүү явалттай, зарим техникүүд нь үйлдвэрлэсэн он тодорхойгүй. Ийм байдлаар асар их хэмжээний хөрөнгө үргүйдэх ийм эрсдэл үүсэж байгаа юм.

Хоёрт нь Эйч Эл Кэй Эм Эн компанийн хооронд байгуулсан Хүнд машин механизмын дугуй худалдан авах Эрдэнэс Тавантолгой 2022/569 дугаартай гэрээ. Гэрээний дүн нь 5000227200 төгрөгийн гэрээ. Илэрсэн зөрчлөөр уг дугуйнууд нь нэг бүр нь 72 орчим сая төгрөгийн өртөгтэй хүнд даацын дугуйнууд байтал хүлээлгэж өгөхдөө дугуйны даац болон хурдны индексүүдийг тодорхойлдог дугуйны дээр байдаг заалтуудыг нь арилгаж нийлүүлсэн. Нэг ёсондоо дугуйны хажуу дээр байдаг нөгөө даацыг нь тодорхойлсон бичгүүдийг нь арилгаж байгаад нийлүүлсэн. Уг дугуйг нь хүлээж авсан ийм зөрчил байгаа.

3.БНХАУ-ын Хонконг Хэнгдэй компанитай байгуулсан хагас коксжсон түли худалдан авах, нүүрс нийлүүлэх гэрээ, 500 орчим мянган тонн түли нийлүүлэх гэрээ.

Энэ гэрээ нь бол Монгол Улсаас хатуу коксжих нүүрс нийлүүлэх, оронд нь Хятад Улсаас хагас коксжих түли нийлүүлэх ийм гэрээ байгаа. Гэрээний хүрээнд Монгол Улсаас 10381 тонн хатуу коксжих нүүрсийг нийлүүлсэн боловч оронд нь авах нүүрсээ аваагүй. Мянга орчим тонн нүүрс авсан. Илгэн компанитай байгуулсан Тавантолгой ордын далд уурхайн хайгуул судалгааны ажил гүйцэтгэх ЭТТ 2022/ 946 дугаартай 69763999500 төгрөгийн гэрээ. Илэрсэн зөрчил нь ҮАБЗ, Засгийн газраас гаргасан шийдвэрүүдийг үргэлжлүүлж Тавантолгой компаниас Тагнуулын ерөнхий газар руу бичиг явуулах замаар олон гэрээнүүдийг нууцад хамруулж хийсэн. Нууцад хамрах ямар ч шаардлагагүй гэрээнүүдийг нууцад

хамруулах замаар явуулсан ийм гэрээнүүд бол үргэлжилсээр байгаа.

Тийм учраас энэ гэрээнүүдийг бид нар жишээ болгон оруулсан юм. Мөн Бодь платиниум компани хооронд Тавантолгой ордын нүүрсний уурхайг гадаргын үерийн уснаас хамгаалах ус, хөв усан сан, хөв цөөрөм байгуулах ЭТТ 2022/567 тоот ажил гүйцэтгэгч 4220187227 төгрөгийн. Энэ бол ерөөсөө ямар нэгэн гэрээгүй шууд ам тохироогоор танайх энийг бараг шууд хийчих, тэгээд хийчихээр нь мөнгийг нь өгнө гэдэг гэдэг байдлаар шууд ингээд ажил эхлүүлээд явсан ийм ноцтой зөрчлүүд байгаа учраас энэ олон гэрээнүүд дундаас жишээ болгож ийм хэдэн гэрээнүүдийг оруулж байгаа юм.

Орон нутгийн Тавантолгой компанийн хувьд орон нутгийн Тавантолгой компани нь бол 51 хувь нь орон нутгийн өмчтэй, 49 хувь нь хувийн өмчийн компани бөгөөд сүүлийн жилүүд компанийн гүйцэтгэх удирдлагыг 49 хувийн төлөөллүүд удирдсаар ирсэн. Үүнтэй холбоотойгоор компанийн ТУЗ-д аймгийн ИТХ-ын төлөөлөгчид орж ажилладаг бөгөөд компанийн хувь нийлүүлэгч ТУЗ-ийн дарга, гишүүд гүйцэтгэх удирдлагуудын хамаарал бүхий ААН-үүд нүүрсний гэрээ болон дотоод худалдан авалтад оролцдог байсан нь шалгалтын явцад тогтоогдсон болно.

Бидний сонсголоор нотлох баримтаар тухайн олон хамаарал бүхий хүмүүсийг нотлох баримтад тулгуурлаж шинжлэн судлах ийм ажлуудыг хийх байсан. Харамсалтай нь одоо сонсгол хийгдээгүй учраас энэ ААН-үүдийг нэгэнт шалгагдаж байгаа учраас оруулах шаардлагагүй гэж ингэж үзэж байгаа юм.

Эдгээртэй холбогдуулаад санал, дүгнэлтийг танилцуулахад төрийн өмчийн эдийн засаг, төсвийн салбар дахь авлигатай тэмцэх үндсэн арга бол төрийн өмчит болон төрийн өмчийн



оролцоотой томоохон компаниудыг олон улсын нээлттэй компани болгон өөрчлөн байгуулж түүнд хамаарахгүй төрийн өмчийн компаниудыг эрчимтэй хувьчлах замаар төрийн үүрсэн ачааллын ихээхэн хэсгийг хувьд шилжүүлэх,

2.Ашигт малт малтмалын экспорт, тээвэрлэлтийн мэдээллийн гааль, боомт, хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааг хамруулсан мэдээллийн нэгдсэн цахим сүлжээ байгуулж импортолж байгаа ерөнхий мэдээллээ тогтмол солилцож байх гэрээ хэлэлцээр байгуулах,

3.Зөрчил гэмт хэргийн шинжтэй мэдээллийг цаг тухайд нь шалгаж шийдвэрлээгүй, ойлгомжгүй шалтгаанаар хэрэгсэхгүй болгосон хууль хяналтын байгууллагын удирдлагатай харууцлага тооцож цаашид ийм байдал үргэлжлэх нөхцөл байдлыг таслан зогсоох.

Цаашид боомтын үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагуудын нэгдсэн удирдлагаар ханган мэдээ тайланг улирал бүр тулган дүгнэлт гаргаж Боомтын зөвлөл Засгийн газарт тайлагнаж байх,

5.Аж ахуйн аливаа ажлыг төрийн нууцад авсан тохиолдолд үйлчлэх тусгай журам гаргах, худалдан авах ажиллагааг зохицуулж байх,

6.Чөлөөт бүсийн үйл ажиллагааг идэвхжүүлж ажлын албыг тухайн нутаг дэвсгэрт шилжүүлэн ажиллуулах,

7.Тавантолгой Гашуун сухайт төмөр замын хил холболтын асуудлыг яаралтай шийдвэрлэж эдийн засгийн эргэлтэд оруулж тээвэрлэлтийн үнийг бууруулах,

8.Тавантолгой-Гашуун сухайт, Зүүнбаян зэрэг төслүүдэд хөндлөнгийн аудит оруулан төслийн санхүүжилт,

өртөг, чанар, үр дүнгийн талаар Улсын Их Хурал тайлан сонсох,

9.Онцгой нөхцөл байдалд үүссэн тухайлах юм бол цар тахал үүссэн нөхцөлд боомт хил гаалийн ажиллах тусгай журам гарган мөрдөх гэсэн ийм саналуудыг оруулж байгаа юм.

Би зарим асуудлуудыг та бүхэнд тараасан учраас хэт нуришаад байгаа учраас товчлоод явчихлаа.

Их Хурал дээр мэдээж энэ асуудлыг зөвхөн товч хэлбэрээр тайлагнаад явах юм. Тэгээд Түр хорооны хурал учраас уг асуудлуудтай холбогдуулаад товч мэдээлэл тайланг танилцууллаа.

Тайлантай холбогдуулаад асуулт асуух гишүүд нэрээ өгье. Кноп дараад явна.

Ганбаатар гишүүнээр тасалъя.  
Ганибал гишүүн асуулт асууя.

**Н.Ганибал:** Мэдээлэлтэй танилцлаа. Манай шинжээч нар бас нэлээдгүй ажилласан байна. Бас мэдээлэл бас тийм муу мэдээлэл биш байна л даа. Уг нь бид нарын үндсэн зорилго бол энэ мэдээллээ нөгөө гэрчүүдийг дуудаж нягтлуулаад тэгээд бодит мэдээлэл болгоод энийгээ ард иргэдэд нээлттэй болгох ийм л үүрэг рольтой нүүрсний тэр нөгөө сонсголыг зохион байгуулъя гэдгээ манай Түр хорооноос санаачилга гараад явсан л даа.

Тэгэхдээ асуудлуудад хэдүүлээ эргээд бас нөгөө нэг хэд хэдэн асуудал дээр маш өндөр дэлгэрэнгүй мэдээллүүд энд байна л даа. Яах вэ зарим нэг нь хууль хүчний байгууллагаараа тодорхой хэмжээнд шийдлүүд нь гарчихсан 2, 3 жил бараг 4, 5 жил одоо олны анхааралд байж байгаад явсан энэ тэр асуудлууд байна. Ер нь тэгэхдээ энэ ингээд нөгөө мэдээлэл маань ингээд зарим асуудлуудаа гээчихсэн байна.

Бид нарын нөгөө үндсэн зорилго маань боомтоор ачаа тээвэрлэсэн нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалган тогтоох гээд уг нь эхэлсэн шүү дээ. Тэгэхэд бид нар дээр хамгийн гол манай Түр хорооны хийсэн ажлууд дотор мэдээж тэр бөмбөлөг тээврийн асуудал байсан шүү дээ. Энэ асуудал нь ингээд орхигдчихсон явж байгаа байхгүй юу. Тодорхой хэмжээнд гааль, хил гаалиар орж гарч байгаа асуудлуудыг нь бид нар ингээд ачиж буулгах талбай, тээвэр хийж байгаа хэд хэдэн компанийн асуудал дээр нь л онцгойлоод арай өндөр дүнтэйнүүд дээр нь л яригдсан байгаа болохоос яг нөгөө бөмбөлөг тээвэр хийж тухайн үедээ юу болж байсан юм, яагаад тэндээс Монгол Улсын эдийн засагт хор хохирол учирсан юм, яагаад тэнд авлигал, тэр хүнд суртлууд байсан юм. Тэнд хэдэн төгрөгийн боломжоо бид алдсан юм гээд тэр асуудлыг бид нар дахиж хэзээ ч гаргахгүй байхын төлөө өнөөдөр бас энэ зөвлөмждөө оруулах, бас олон нийтэд мэдээллийг нь ил тод болгох зайлиггүй шаардлагатай байсан. Шаардлагатай гэж ойлгож байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг бид нар бас мэдээж манай шинжээч нар маань энэ асуудал дээр ажилласан.

Хоёр дахь асуудал нь төмөр замын тээврийн асуудал.

Бас тухайн үед хамгийн Их Монгол Улсын эдийн засагт хамгийн их хохирол учруулсан тэр ганц боломжийг хэдэн тэр асуудлыг хариуцсан дарга нар ч юм уу түүнийг зуучилсан зуучлагч нар бас Монголын эдийн засгийн том боломжийг алдагдуулсан. Энэ асуудал бас яагаад орж ирсэнгүй байна вэ? Энийг оруулмаар байна гэдгээ бас саналаа хэлчихье. Асуулт дээрээс нь санал.

Мэдээллүүдийн одоо яах вэ ингээд 2 том, нэг том юугаа л яриад л байна л даа хэдүүлээ. Зүүнбаянгийн төмөр замын

асуудлыг маш дэлгэрэнгүй маш тодорхой, дэлгэрэнгүй ярилаа. Бусад тэр Норинкотой хийж байгаа энэ юуны асуудал байна л даа. Энэ нефть дамжуулах хоолойн асуудал байна. Энэ асуудал дээр бас бид нар ер нь зүгээр үнэхээр зүгээр юу гээд орхиод яваад байх юм. Энэ 2 тал нууц юм чинь гээд манай Үйлдвэржилтийн байнгын хороон дээр энэ асуудал маш тодорхой яригдчихсан байхгүй юу. Энэ энэ болохгүй байна. Энэ ажлууд чинь ингээд яг бодитой ажил хэрэг болоод явж чадахгүй байна. Тэгэхээр энэ асуудлууд дээр Улсын Их Хурал, Засгийн газар бүгдээрээ анхаарлаа хандуулж байж энэ асуудлуудынхаа ард гарахгүй бол эргээд 5 жилийн дараа ч байдаг юм уу 2026 онд энэ үйлдвэр ашиглалтад орохгүй тэр дамжуулах хоолой нь ашиглалтад орохгүй ажиллаж чадахгүй бол бид нар яах юм?

Өнөөдөр шийдвэр гаргасныхаа төлөө аль эсвэл энэ үнийг хянасныхаа хянах ёстой үүргийнхээ төлөө бид ирээдүйн том боломжуудыг алдчихаад тэгээд бидэнд хамаагүй гээд суух тийм бас эрх байхгүй байх л даа. Тэгэхээр энэ асуудлыг бас явал нээлттэй болгож хэлэлцэх ёстой юм. Тэрийг бид нар хэлэлцэх ёстой байх.

Төмөр замын бодит бол яах вэ ингээд ойлгомжтой бүх мэдээллүүдийг нь бид нар аваад олсон орлогыг нь хүртэл тоолоод харж чадаж байна шүү дээ.

**Г.Ганболд:** Ганибал гишүүний асуултад хариулъя. Таны хэлж байгаа бол үнэн. Тийм учраас бид нар энэ бөмбөлөг тээвэр PCR шинжилгээтэй асуудлыг бол Бейсен гишүүн бид нар бол тухайн үед нь бол идэвхтэй шалгаж гаргаж ирсэн. Тухайн үедээ энэ цар тахалтай холбоотой нэгэнт болоод өнгөрсөн зүйлүүд учраас бид нар бол энэ дээр дүгнэлтдээ. Ер нь онцгой нөхцөл байдал үүссэн үед манайх ерөөсөө энэ мөрдөх хууль журам гаргахгүй гэнэт цар тахал гарангуут ингээд хөл толгойгүй болдог. Боомт нь юу хийх юм, гааль нь

юу хийх юм гээд. Тэр бол одоо бөмбөлөг тээвэртэй холбоотой асуудал. Бид нар биччихсэн зүйл бол манай шинжээчид Адъяацэрэнгийн гаргасан дүгнэлтүүд байгаа.

Тэгэхээр маргааш бид нар Их Хурал дээр оруулахдаа энэ хэсэг хэсгүүдийг та бүхэн шаардлагатай гэвэл тэр дүгнэлтүүдээ оруулж болно. Бид нар зүгээр энэ дээр гол нь оруулахдаа яасан гэх дээр зэрэг нөгөө сонсгол хийх гэж байсан 3 сэдвийнхээ хүрээнд л ингээд оруулаад явж байгаа.

Тэгэхээр таны хэлж байгаа яг тэр бөмбөлөг тээвэртэй холбоотой бид нар бол яг сонсгол хийсэн тохиолдолд яг тэр бөмбөлөг тээврийн эсвэл тэр хоосон гарсан машинуудыг компаниар нь нүүрс ачиж буулгах талбайгаар нь хоосон гарсан яг машины жолооч нарыг нь авчирч ингээд оруулахаар ингээд төлөвлөж байсан юм. Энэ бол боломжгүй болсон гэдгийг та мэдэж байгаа. Мэдээж төмөр замын асуудал энэ Батмөнх гээд манай шинжээч энэ асуудал дээр бол идэвхтэй ажиллаж байсан. Төмөр замын асуудлыг бид нар сонсголд оруулахад төлөвлөсөн. Тэгэхдээ шалгалтын явцад ингээд энэ Батдөлийн хэрэг энэ тэр гээд яриад байгаа ийм ноцтой зүйлийг чинь манай шинжээчид тогтоогоод төмөр замын цагдаагийн газар тийм ээ, Батмөнх өө тийм. Төмөр ЗЦГ-т ийм асуудлууд байна гэдгийг шалгуулахаар Түр хорооноос хүсэлт тавьж энэ асуудлууд гарч ирсэн.

Тэгэхээр бол энэ өөрөө нэгэнт хуулийн байгууллага дээр шалгагдаад явж байгаа. Тэгэхээр АТГ-аас нөгөө сонсгол зохион байгуулахад яг мөрдөн байцаах ажиллагаанд саад учрах гээд байна гэдэг гол үндэслэлүүдийн нэг нь бол яг энэ хэрэгтэй холбоотой асуудал учраас бид нар энд дэлгэрэнгүй оруулах боломжгүй байгаа юм. Тэрнээс энэ асуудал бол яг манай Түр хорооны хянан шалгагчдын хүрээнд гарч ирсэн асуудал. Тэгээд энийг бол Тайланд бас бид нар тайланд тусгахдаа бас яг одоо энэ

шалгагдаж байгаа зарим асуудлуудаар оруулах боломжгүй зүйлүүдээ оруулаагүй тэгээд боломжтой гэсэн зүйлүүдээ л оруулж байгаа юм. Яг таны асууж байгаа зүйл зөв л дөө. Бид нар бол нэг цөөхөн хүрээнд яриад байна гэж.

Тэгэхээр би бол ил болгосон гэрээнүүдийн хүрээнд бол одоо ил болгосон гээд байгаа боловч Норинко, Чалко 2-той холбоотой гэрээ байна. Гэхдээ энэ Чалкотой холбоотой бас Норинкогийн 2 гэрээ байгаа шүү дээ. Нефтийн хоолой мөн нүүрс угаах энэ 2-той холбоотой Эрдэнэс Тавантолгойн зүгээс бид нарт ямар хүсэлтүүдийг тавьж байна гэхээр зэрэг энэ компаниуд гэрээ байгуулахдаа аль нэгэн Чалко Норинко 2 нь ТӨК-ууд энэ агуулгаараа бол аль нэг компанийн зөвшөөрөлгүйгээр гэрээг ил болгох юм бол нөгөө компани нь асар их хэмжээний торгууль төлөх ийм гэрээний заалтуудтай учраас бид нар ил гарах боломжгүй байна гэдэг ингээд зүйл яриад байгаа юм.

Тэгэхээр зэрэг энийг бид нар ингээд дэлгэх боломжгүй болчхоод байгаа юм. Дараа нь ингээд олон улсын арбитраар ороод явах юм Эрдэнэс Тавантолгой компани бас асар их хэмжээний торгуульд орох ийм асуудал байгаа учраас энийг ингээд гаргаж ирэх боломжгүй байна тэгэхээр зэрэг бид нар энийг цаашидаа энэ дүгнэлтдээ нэгэнт энэ төрийн өмчтэй ард түмний хувь эзэмшдэг компанийг төлөөлөөд байж байгаа энэ ТУЗ, гүйцэтгэх удирдлагууд ТӨК-ийн өмнөөс ийм гэрээ хийхийг бүр хязгаарлаж хориглох ийм заалтуудыг бид нар энэ дүгнэлтдээ оруулаад явах ийм боломж байгаа юм.

Түүнээс биш зөвхөн ганц нэг компани дээр ороод байгаа зүйл биш ээ. Бид нар бол энэ шинжээчид нээлттэй байгаа ийм компаниуд дээр гаргасан дүгнэлтүүдийг бид нар ингэж оруулж байгаа гэдгийг хэлье ээ.

Ганибал гишүүн тодруулъя.

**Н.Ганибал:** Яах вэ тэгээд хэдүүлээ нэг өмнөх бас нөгөө Хөгжлийн банкны түр хорооны алдааг давтахгүй бас явах нь зөв байх л даа. Ард түмэн бол маш өндөр мэдээлэлтэй байгаа. Тэгээд үнэн мэдүүлэхийн төлөө бид нар бас ажилласан байх ёстой л гэж бодож байгаа. Тэгээд нөгөө нэг л хүний нэр дор энэ дотор аягүй тод гарч ирж байгаа байхгүй юу. Баттулга гэдэг хүний ажлын өрөөнд ажлын хэсэг хуралдаж байсан гээд. Үгүй тэр үед нь тэгээд тэр Ерөнхий сайд нь юу хийж байсан юм. Манай Ерөнхийлөгч байсан биз дээ тэ? Тэр үед нь Их Хурлын дарга нь яагаад тэр хууль тогтоомж нь тэр Ерөнхийлөгчийн өрөөнд ажлын хэсэг хуралдаж болохгүй гэж мэдсээр байж яагаад тэр асуудлуудыг нь зогсоогоогүй юм. Ер нь яагаад ер нь Монгол Улсын Ерөнхийлөгч тэнд ажлын хэсэг ахлаад л хуралдаад байдаг байсан юм. Энэ асуудал нь өөрөө бас нэлээн ээдрээтэй асуудал шүү. Энэ дээр бас хэдүүлээ зөвхөн нэг талыг нь ярина гэвэл бүгдийг нь л ярих ёстой байх. Ингэж байж хэдүүлээ энэ юмныхаа ард гарахгүй зүгээр л нэг энэ удаагийн нэг сонсголоор.

**Г.Ганболд:** Энэ бол Түр хорооны тайлан. Би бол нөгөө шинжээчдийн гаргаж ирсэн дүгнэлтүүдийг одоо би өөрөө яг боловсруулж байгаа зүйл биш шүү дээ. Шинжээчдийн гаргаж ирж байгаа дүгнэлтүүдээ л би ингээд оруулж байгаа юм. Хэдүүлээ одоо энэ дээр хуралдаж байгаад тэгээд маргааш Их Хурал дээр оруулах зүйлүүддээ та хэдийн саналыг яаж оруулах вэ? Нээлттэй.

Ер нь бол тухайн үеийн одоо бид нар хяналт шалгалт хийх явцад энэ Аюулгүйн зөвлөлийн протоколуудыг тухайн үеийн бүхий л энэ протоколууд нь бол Эрдэнэс Тавантолгой компани дээр, Монголын Төмөр зам компаниуд дээр очсон мэдээллүүдээс үзэхэд бол зөвхөн ажлын хэсгийн хурал нь ингэж л явж байсан л тийм протоколууд байгаа юм. Бүх л протокол нь ингэж явж байсан. Харин энэ яг энэ дүгнэлт гаргасан

шинжээч нь гадаад руу томилолтоор явсан учраас тэгээд энэ бол зүгээр ийм л юм байгаа юм. Зүгээр яах вэ би хууль зөрчсөн эсэхийг бид нар бас дүгнэхэд амаргүй. Энэ өөрөө Засгийн газраас байгуулсан ажлын хэсэг Зүүнбаян төмөр замын ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий ийм ажлын хэсэг. Тэгэхдээ ажлын хэсгийн хуралдаан нь ер нь бол тухайн үеийн Ерөнхийлөгчийн албан өрөөнд л явагдаж байсан ийм протоколууд байгаа. Тэр протоколууд дээрээс л бид нар гарч ирсэн ингэж явж байсан, тэгэхээр зэрэг энэ аж ахуйн төрийн институцүүдийн ажлын уялдаа холбоо гэдэг юм уу энэ нь бол бас нэг газраас ингээд тухайн төслийг удирдаж байсны нэг илэрхийллээ л гэдэг байдлаар оруулсан.

Энхтүвшин гишүүн асуулт.

**Т.Энхтүвшин:** Баярлалаа. Хоёр асуулт байж байна. Зүгээр тайлан дээрээс харлаа 1 дүгээрт энэ Тавантолгой Гацуун сухайтын төмөр зам яг 1 км нь хэдэн төгрөгөөр баригдсан юм бэ? Янз янзын л тоо яваад байх юм. Яг 1 км төмөр замын өртөг нь яг хэд юм бэ? Би бол одоо төмөр зам гэдгийг юу гэж ойлгож байна гэхээр төмөр зам бол юу гэдэг юм, дохиолол холбоотой, өртөө зөрлөгтэй, салаа замтай. ингээд төмөр замын одоо юу гэдэг юм дэд бүтэц, доод бүтэцтэйгээ нийлээд төмөр зам болдог л гэж ойлгож байгаа юм.

Тэгэхээр энэ бүтцүүд нь нийлээд 1 км нь хэдэн төгрөгөөр боссон юм бэ гээд ганцхан одоо юу гэдэг юм төмөр зам юу гэдэг юм, дээд бүтэц, доод бүтцээрээ төмөр зам болохгүй шүү дээ. Тэр чинь өртөө зөрлөг, дохиолол холбоо, бүх юмтайг нь нийлж салаа зам эд нар нийлж байж л төмөр зам болж болж байгаа юм. Тэгэхээр 1 км төмөр замын өртөг нь яг хэдэн төгрөг болж байгаа юм бэ? Бусад одоо төмөр замын бүтээн байгуулалттай харьцуулж үзэхэд тэр нь хэдэн төгрөгөөр илүү болоод байгаа юм. Тэрнийг надад нэг хэлж өгөөч.

Хоёр дахь асуудал энэ 16 зүтгүүр вагоны асуудал бас яригдаад байгаа. Энэ тайлан дээр болохоор юу гэдэг юм нэг зүтгүүрийг нь 4.3 сая доллароор авахаар шийдсэн юм байна. Харин юу гэдэг юм яг энэ зах зээлийн үнээр одоо 2.5 сая доллар гэсэн мэдээлэлтэй байна гээд ийм мэдээлэл оруулсан байж байна. Энэ хэр бодитой юм бэ. Тэгээд энэ зүтгүүр одоо юу гэдэг юм одоо ирчихсэн байгаа юу? Авсан байгаа юу? Тавантолгой Гашуун сухайтын төмөр зам дээр энэ зүтгүүр ашиглагдаж байгаа юу гэдгийг асуумаар байж байна.

Гуав дахь асуудал энэ Богд хаан төмөр замтай холбоотой асуудал яригдаад байж байгаа. Тэгээд Богд хаан төмөр замын асуудал бол зогссон байж байгаа. Тэгээд зогсчихоод байхад энэ энэ мэдээллийг уншихад нэг ийм юм байна л даа. Түр зогсоосон байгаа л гэж байгаа юм. Тэгээд зогсоосон байдал Бодь интернэйшнл компанид 26.3 сая ам долларын нүүрсийг БНХАУ-ын 11 компани худалдан авагчид нийлүүлсэн байна гээд байгаа юм. Зогсоочоод байхад ингээд энэ мөнгийг нь нийлүүлчихсэн юм уу? Хэрвээ зогсоогүй байхад нь нийлүүлчихсэн юм уу гэдэг. Энийг нэг ялгааг нь нэг хэлж өгөөч. Энэ ингээд харж байхад түр хугацаагаар зогсоосон хэдий ч 2023 оны эхний улирлын байдлаар Эрдэнэс Тавантолгой компаниас Бодь Интернэйшнл компанид 26.3 сая амдолларын нүүрсийг БНХАУ-ын 11 худалдан авагчид нийлүүлсэн байна гээд ингээд зогсоочихсон байхад нийлүүлчихсэн юм шиг биччихсэн байна шүү дээ. Тэгээд энийг надад нэг бас нэг салгаж хэлж өгөөч гэж хэлмээр байна. Ийм 3 асуудал байна.

**Г.Ганболд:** Ер нь бол бид нар одоо ингээд яг сонсгол хийж чадаагүй учраас ингээд шууд нэг талын дүгнэлтээр юм ярихад их төвөгтэй болоод байгаа нь эндээс харагдаж байгаа юм. Уг нь бид нар яг сонсгол хийсэн бол яг манай шинжээчдийн дүгнэлтээр нөгөө оролцогч

талынхныг дуудаж ирээд 2 талаасаа нотлох баримтаа гаргаад ингээд мэтгэлцсэн бол нийгэмд илүү ойлгомжтой. Одоо бид нар бол нэг талын шинжээчийн дүгнэлтийг л барихаас өөр аргагүй болж байгаа юм. Сонсгол хийгээгүй учраас. Бид нар нэгэнт одоо шинжээчдийг өчнөөн хоног цаг зав гаргаж ажиллуулсан учраас шинжээчдийнхээ дүгнэлтийг л үндэслэж ярихаас өөр арга байхгүй ээ. Төмөр замын өртгийн хувьд бол Тавантолгой Гашуун-сухайт төмөр зам бол 1 дүгээр зэрэглэлийн төмөр зам. Тавантолгой-Зүүнбаян төмөр зам бол 3 дугаар зэрэглэлийн төмөр зам. Энэ 2-ын зөрөө нь бол үндсэндээ далан шороог нь 1 дүгээр зэрэглэлийн төмөр зам бол 20 сантиметр тутамд нь нягтруулна, 3 дугаар зэрэглэлийнхийг нь бол 30 сантиметр тутамд нь даланг нь нягтруулах. Дээгүүр нь явж байгаа дэр төмрийн хувьд бол 1 дүгээр зэрэглэлийнх нь бол залгаагүй. 3 дугаар зэрэглэлийнх нь залгаатай. ЗТЯ-наас ирүүлж байгаа мэдээллээр бол таны асуусан яг дохиолол холбоо тэгээд өртөө зөрлөгтэйгөө нийлэх юм бро 3 сая гаран доллароор 1 км авто зам баригдсан гэж үзэж байгаа.

Тэгэхээр зэрэг бол энэ өртгийг бол та бүхэн мэдэж байгаа байх. Зүүнбаян төмөр замынх бол 1 сая 50 орчим мянган доллароор баригдсан. Тэгээд эндээс харах юм бол Зүүнбаян төмөр замаас 3 дахин өндөр өртгөөр баригдсан гэж ойлгож болно. Энэ толгойтой холбоотой асуудал бол анхаарал татаж байгаа. Шинжээчид бол энэ дээр бүүр онцгой анхаарал хандуулж ажилласан. Айкомын ТЭЗҮ-ээр бол дараагийн домэйны ТЭЗҮ-ээр ч гэсэн ер нь бол вагоны толгойн сонголт их буруу байсан гэж дүгнэж байгаа.

Нэгдүгээрт нь ТЭЗҮ дээр 18 толгой оруулж ирэхээр байсан бол энэ гэрээнд 16 толгой буюу, 2 толгой дутуу нийлүүлэгдэж байгаа. Одоогоороо нийлүүлэгдэж ирээгүй байгаа. Монголын төмөр замын хийж байгаагаар бол 9-өөс

10 сарын үед нийлүүлэгдэнэ гэж байгаа юм. Энэ дээр нэг ноцтой зүйл бол энэ Америкийн компаниас нийлүүлж байгаа энэ цуврал бол нарийн царигийн толгойг өргөн цариг руу шилжүүлсэн ийм анхны модель. Энэ агуулгаараа бол яг энэ модель нь дэлхий дээр хаана ч ашиглагдаагүй ийм модель ирж байгаа гэдэг дүгнэлтийг гаргасан. Домейн, Айкомын ТЭЗҮ 2 дээр гаргасан энэ толгойн зүтгүүрийн сонголт шууд бол шууд заачихсан. Энэ одоо өргөн царигийн төмөр зам дээр бол энэ чиглэлийн зүтгүүрийг сонгоно гэж заачихсан байхад энэ дээр бол заагаагүй байгаа юм.

Угаасаа энэ нууц гэрээнд хамруулсан гэрээн дотор бол явах ангийг бол ерөөсөө шууд нууцад хамруулж гэрээ хийхээргүй байсан юм. Гэтэл энийг нэмэлтээр хийсэн. Нэг ёсондоо бол одоо бид нар мэдэхгүй байгаа боловч Бодь компанитай хийсэн энэ анхны гэрээн дээр өнөөдрийн байдлаар нэмэгдээд 400 орчим сая долларын нэмэлт гэрээ хийгдчихсэн явж байгаа. Өмнө нь Айкомын ТЭЗҮ дээр нэмэгдээд. Домэйны 213 сая долларын гэрээ. Дээр нь тойрог замын 70 сая долларын гэрээ. Тэгээд нүүрс ачиж, буулгах талбайн 109.9 сая долларын гэрээ гээд нийтдээ 4 зуугаад сая долларын нэмэлт гэрээ хийгдээд л яваад байгаа өнөөдрийг болтол тэр компанитай. Тэгэхдээ бид нар энд нүүрсээ 13 хувийн хөнгөлөлттэй өгөөд л байгаа юм. Ийм зүйл байгаа юм.

Тэгэхээр энэ дээр бол та саяынх тэгж ойлгож болно. Богд хаан төмөр замын хувьд манай шинжээчдийн гаргасан дүгнэлт дээр бол энэ өөрөө 1.4 тэрбум долларын гэрээ мөн. Энийг бас яг өмнөхтэй адилхан гүүрэн болон стакадан гүүрүүдийн энэ бодь бусад далан шорооны ажлууд болон дээд ангийг нь УБТЗ далан шорооны ажлыг зэвсэгт хүчин хийхээр тооцоолсон. Гэрээ хийгдсэн. Засгийн газраас түр зогсоосон гэж байгаа боловч энэ оны эхний улирлын байдлаар зөвхөн Бодь компани гэхэд 26.6 сая долларын хөнгөлөлттэй нүүрс

олгочихсон байгаа. Тэгээд энэ асуудлыг бол цаашидаа хэрэвзээ бүрэн гэрээг цуцлах юм бол энэ олгосон нүүрснүүдийг яах вэ. Эсвэл одоо энэ үргэлжлэх үү гэдэг асуудлыг бид нар ярихаас өөр арга байхгүй зүйл байгаа юм.

Бейсен гишүүн.

**Б.Бейсен:** Ажлын хэсэгт нь хилийн боомтууд, ачаа тээвэр, нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн ажиллагаа учирч байгаа зөрчил дутагдал, хүндрэлийг шалган тогтоох, үүрэг бүхий хянан шалгах шалган тогтоох үүрэг бүхий түр хорооных л доо. Энэний дагуу бид бас энэ газар дээр нь Ховд, Цагааннуурын боомтоор явсан. Хөшөөтийн уурхайн нүүрсийг шалгасан. Одоо энэ зарим хэвлэл мэдээллийнхэн салахгүй байна. Та нар эвлэрчхээд мөнгө авчхаад больчихсон уу маягийн юм ярьж байна л даа. Энэ Хөшөөтийн уурхай, Монэнко компани, Тэс майнинг гээд нийтдээ 1 31 ААН ажиллаж байгаа юм байна шүү дээ. Нүүрс тээвэрлэлт хийгээд. Мөн Увсын, тэр Наранбулагийн Харганатын төмрийн хүдрийн асуудал тэр Тайширын боомтоор гарч байгаа юм. Энэ дээр бид нар тодорхой хэмжээний баримт шинжээчдэд өгсөн. Шинжээч нар ерөөсөө хариуцлагагүй ажилласан гэж үзэж байна би ерөөсөө. Ийм хэмжээний мөнгө улсын баялаг алдагдаж байхад тэрийг шалгаад бид нарт тайлангаа ч өгөөгүй ирсэн. Тухайн үед нь бүгдээрээ сайн хийнэ гээд ярьсан одоог хүртэл юуг нь өгөөгүй. Энэ асуудал дээр нэлээн тайланг нь сонсмоор байх юм тэр шинжээчдийн. Ядахдаа ажлын хэсэгт нь өгчхөж болно шүү дээ.

Хоёрдугаарт Цагаан нуурын чөлөөт бүсийн асуудал дээр сая бид нар бас очоод ирсэн энэ таны тайлан дээр энийг татан буулгах идэвхжүүлэх гээд бичсэн байна. Сая бүүр шившиг болсон. Тэнд нээлт дээр нь би очсон тэнд байж байгаад бас ажилтай явж байсан. Манай нөгөө 2 гишүүн очоогүй. Цаанаасаа ерөөсөө юу нь ирээгүй.

Хөрөнгө оруулагч хотоос хүртэл улсууд очсон. ААН компаниуд очсон. Зүгээр Өлгийн захыг нүүлгэж аваачаад нээлт хийсэн маягтаа ингээд шоу хийж ерөөсөө болохгүй. Удирдлага нь хотод байж байдаг цалин аваад 20, 30 ажилчин. Ингээд ард иргэд доромжилсон маягтай хилээр тэр нэг Худалдаа аж үйлдвэрийн танхимыг ч хэлээд ажиллаагүй. Оросууд ирэх юм хятадаас ирэх юм гэсэн 2 3 төлөөлөгч л ирсэн. Тэгээд тэр чөлөөт бүс нэртэй юм хийсэн.

Тийм учраас энийг Засгийн газарт тодорхой хэмжээнд танилцуулахгүй бол 17 жил хий цалин аваад байж байна шүү дээ одоо. 20, 30-аад хүн ирсэн хотод захиргаа нь байдаг тухайн орон нутагт ажилладаггүй. Хоосон хашаа байж байдаг. Энэ асуудлыг бас шинжээчид бас шалгаад тодорхой хэмжээний тэр энэ нүүрсний асуудал гээд нэлээн олон удаа яригдлаа. Одоо жижиг Тавантолгойгоор нь Ажнай гишүүнээр нэг туг тахисан болоод л тэгээд бусдыг ярихгүй юм. Том ААН дээр өчигдөр бас хэвлэлээр ярьж байна шүү дээ. Жинхэнэ том ордтой газрыг нь гадаадын хөрөнгө оруулагчид өгчихсөн. Телевизээр ярьж байна. Гэтэл ингээд бид нарыг шахдаг нүүрс тээвэрлэлт тэр газрын хөрс хуулалтын асуудал дээр зовж байна бид нар гээд ярьж байна.

Тийм учраас одоо Их Хурал юунд танилцуулахдаа ажлын хэсэг тодорхой хэмжээний дүгнэлтээ танилцуулахгүй бол болохгүй байх гэсэн санал хэлье.

**Г.Ганболд:** Бейсен гишүүний асуултад хариулья.

Бейсен гишүүн бид нар цуг баруун хэлүүдээр явсан л даа. Тэгээд Цагаан нуур боомтын хувьд таны хэлсэн арван хэдэн жил болчихсон. Тэгээд тэнд бол нэг хашаа л байгаа шүү дээ тийм ээ. Та мэдэж байгаа. Тэгсэн хэрнээ боомтын удирдлагууд нь энд цалин аваад байж байдаг 17 жил бараг цалин аваад байж

байгаа. Тэнд бол ерөөсөө одоо очоод асуухад бол нэг асар том хашаа. Өчнөөн тэрбум төгрөгөөр нэг том хашаа барьсан. Ид шид нь бол нэг цас шуурга болох юм бол малчид малаа оруулдаг ийм л зүйл байгаа шүү дээ. Тийм учраас хэрэвзээ эсвэл одоо ингээд дүгнэлт дээр нэг ийм л зүйл байгаа юм.

Эсвэл тэрийг одоо энд байгаа чөлөөт бүсийн захиргааг нь тэнд нь очиж ажиллуулаад үйл ажиллагааг нь явуулах, эсвэл ерөөсөө татан буулгах гэдэг ийм л саналыг бид нар оруулахгүй бол энд байгаа хүмүүс нь тэндээ бараг очиж үзээгүй хүмүүс хүртэл байна. Тэгээд энэ чиглэлээр нэг иймэрхүү санал, дүгнэлтүүд гарсныг ер нь бол зарим нэг чөлөөт бүсийг бол үнэхээр болохгүй бол энэ цалин хөлс үрж байж байхаар татан буулгах нь зөв юм байна лээ л гэсэн дүгнэлт хийгээд байгаа юм Бейсен гишүүн ээ.

Тэгээд та материал өгсөн л дөө. Жишээлэх юм бол Булган боомттой холбоотой Хятадын Шиньжиан Уйгарын телевизээр ийм мэдээ гарсан. Энэ нь ингээд Булган боомтыг гарсан нүүрстэй зөрөөд байна гэдэг. Тэгээд энэ зөрөөд байгаа асуудлыг бид нар таны өгсөн даруйд цагдаагийн байгууллага энэ ГЕГ-ын тухайн үеийн удирдлагуудад өгөөд тэгээд тэд нарын хувьд ерөөсөө ямар ч зөрөө байхгүй ээ. Булган боомт дээр тийм зөрөө гарах боломжгүй. Тэгээд яг таарч байгаа учраас энэ таны мэдээлэл хоногийн зөрөөтэй мэдээлэл байж магадгүй байна гэдэг байдлаар орхисон. Та тэрийг мэдэж байгаа тийм ээ. Тухайн үед нь би яг таныг хурал дээр байхад тэр ГЕГ-ын даргаар ажиллаж байсан асуултаас яг таны өгсөн мэдээллийг асууж байсан шүү дээ. Яг энийг тодруулаад өгөө гээд. Тэгээд энэ асуудлаар яг зөрөө байхгүй учраас энэ ийм зүйл байна гэдгийг та бүхэн мэдэж та мэдэж байгаа. Тэгээд бид нар яах вэ 3 сонсгол хийх гэж байсан сэдвийнхээ хүрээнд явж байна.

Тэгээд маргааш би Их Хурал дээр оруулахдаа боомттой чөлөөт бүстэй холбоотой асуудлаар бол нэмээд яг Их Хурал дээр гаргах тайлан дээрээ бол нэмэлт зүйлүүдийг оруулчхаж болно. Та бүхэн ч гэсэн энэ дээр ийм зүйлүүдийг нь оруулъя, энэ саналуудыг санал, дүгнэлт дээр оруулъя гэвэл болно. Бид нар бол танд шинжээчдийн дүгнэлт, тайлан гээд нэлээн зузаан юм байгаа л даа. Тэрэн дээр бол уул нь бас дэлгэрэнгүй зүйлүүд байгаа. Тэгээд тэрийг би яахгүй тэндээсээ товчилж байгаад л уг нь нэг 20 гаруй хуудас юмнууд жаахан ноцтойдуу юмнуудыг та бүхэн хэт олон болохоор бас уншиж амжихгүй байсан. Энэ дотор бол бас нэлээн ноцтой зүйлүүд зөндөө байгаа л даа. Ер нь бол. Тэгэхээр ийм зүйлүүд дээр би бас ямар ч гэсэн энэ сонсгол хийх гэж байсан 3 сэдвийнхээ хүрээнд л та бүхэнд танилцуулсан юм.

*Бейсен гишүүн тодруулъя.*

**Б.Бейсен:** Тэр нэг 5-аас 6 хоногийн дараах мэдээлэл л дээ. Тэгэхээр чинь 300, 400 мянган тонн тэгж ч зөрөөтэй гарах ёсгүй гэнэ. Мэдээллийг нь зөв авсан. Энийг одоо ингээд л зүгээр орхичхож болохгүй байх. 50-аас 60 сая долларын нүүрс гарсан, нэгдүгээрт.

Хоёрдугаарт тэр чөлөөт бүсийн асуудлаар сая би Энхтүвшин гишүүн бид хэд гадаадад яваад ирсэн. Газар ололтын асуудлыг нь чөлөөлж өгөөд тэгээд бас бүх дэмжээд хөрөнгө оруулагчид дэмждэг юм байна. Энэ талаар Энхтүвшин гишүүн бас ярих байх гэж бодож байна.

Цагааннуур дээр тийм юм хийгдсэн нэг ч юм байхгүй ерөөсөө. Энэ талаар тодорхой хэмжээний тайланд оруулах шаардлагатай. Одоо хотод байх шаардлагагүй. Тийшээ аль эсвэл очоод ажил хий гээд.

**Г.Ганболд:** Бейсен гишүүнээ нэг ийм л байгаа юм л даа. Бид нар чинь одоо ерөөсөө энэ нүүрсний хулгай гээд байгаа

юм бол 2013 онд нөгөө гааль дотоод шалгалтаараа анх ингээд тогтоож байх үед бол Хятад, Монголын гаалиуд ингээд хоорондоо мэдээллээ ингээд солилцоод зөрүүгөө тогтоодог байсан. Тэрнээс хойш ингээд Хятадын тал гаалийнхаа мэдээг өгөхөө больсноос болоод л энэ хөл толгойгүй ийм болсон шүү дээ. Тэр агуулгаараа ингээд таны тэрийг ингээд нотлоход их төвөгтэй байгаа юм. Одоо энэ тэр манай шинжээч Онгонцэцэг гээд шинжээчийн хувьд энэ олон сайтуудаас энэ Хятадын экскуул тэгээд л Америкийн сайтуудаас ингэж Монголын мэдээтэй тулгаж байж гаргаж ирж байгаа мэдээ нь зөвхөн бид нарын энэ шалгалтаар илэрсэн тэр Гашуун сухайт дээр гэхэд та бүхэн анзаарсан бол зөвхөн хоёрхон нүүрс ачих буулгах талбай дээр ерөөсөө тав, зургаахан сая тонн нүүрс наанаас буугаад тэгээд цаашаа бүрдүүлэлт хийгээд гарахад л 1.1 сая тонн нүүрс дутаж байгаа байхгүй юу.

Эсвэл наад бусад талбайнууд дээр нэг наймхан сая тонн нүүрс талбай дээр буухад цаашаа 2 сая тонн нүүрсний илүү бүрдүүлэлт хийгээд гараад явчхаж байгаа байхгүй юу. Тэгээд энэ болгон бол одоо манай шинжээчийн дүгнэлтийг бол би бодитой байна гэж үзэхэд хүргэж байгаа юм. Одоо наанаас нөгөө тэр 2 сая тонн нүүрс хулгайд алдагдана гээд нөгөө илүү гарна гэдэг бол нөгөө наад талын эх үүсвэргүй уурхайн амнаас алдагдсан юм уу нөгөө мөргөцөг алга болчихсон гээд байгаа хулгайнууд чинь яг тэрэнд байгаа байхгүй юу.

Эсвэл илүү наанаас бага нүүрс буунгуутаа илүү гараад явчихсан. Дутаж байгаа нь болохоор зэрэг наанаас нүүрс буучхаад цааш нь дутуу бүрдүүлнэ гэдэг маань одоо нөгөө бид нарын хоосон гарсан машин гэж яриад байгаа. Хоосон гарсан машин гэж яриад байгаа зүйл шүү дээ. Тэгэхээр зэрэг энэ нь бол нөгөө энэ гаалийнхны гаргаж тавиад байгаа хэдэн мянган машин хоосон гарсан. Энэ нь бол татвартай холбоотой ийм зүйлүүд байгаа юм.



Тэгэхээр энэ дээр бол Бейсен гишүүн яг тэр Булган боомттой холбоотой тэр Хятадын телевизийн мэдээллийг бид нар нотлоход их төвөгтэй байгаа юм. Хятадын телевизээр ийм мэдээ өглөө 5 хоногийн зөрөөтэй гээд тэгээд тэрийг нь наад тал дээр нь тулгахлаар зэрэг Булган боомт та бүхэн мэдэж байгаа. Харьцангуй нэгхэн компани гаргадаг учраас цэгцтэй. Өдөрт цөөхөн машин гардаг учраас тэр хоосон гараад явах тийм боломжууд багатай байсан гэдгийг та мэдэж байгаа. Тийм ээ цөөн машин гардаг учраас.

Ер нь бол эндээс ингээд харж байхад одоо жишээлэх юм бол өдөрт бид нарын гаргасан энэ шалгалтаар үзэх юм бол хамгийн олон Гашиунсухайт боомтоор өдөрт 171 бүртгэлгүй машин гарсан байгаа. Хамгийн олон нь. Би энэ тайландаа түүгээд гаргасан 3 өдрийг түүсэн байна шүү дээ. 2021 оны 3 сарын 1-нд 147 машин, 2021 оны 10 сарын 9-нд 74 машин, 2021 оны 10 сарын 15-нд 71 машин гээд. Энэ бол нөгөө олон машин бүртгэлгүй гарсан өдрүүдийг нь түүж авч үзсэн. Тэрнээс бүх өдрүүдээр нь бид нар түүх юм бол энэ цөөхөн хянан шалгагч шинжээч нарын хувьд ямар ч боломжгүй. Тэгэхээр энэ цөөхөн машинуудаас ингээд түүгээд үзэхэд л нөгөө түрүүний гаргасан Качфлов гээд компанийн машинууд яг тэр хоосон гарсан машинууд дотор явж байгаа байхгүй юу. Тэгээд энүүгээр л бид нар бол тогтоож нотлох гэж оролдсон юм. Одоо сонсгол хийсэн бол яг л энэ зүйлүүдийг гарсан жолооч нарыг нь тухайн өдөр гарч байсан гаалийн байцаагчийг нь, яг бүртгэлүүдийг нь бид нар ингээд нотлох баримтаар тулгаад л яг энэ машин тэр өдөр гарсан байна, наанаас компани дээрээсээ тэдэн тонн нүүрсний бүртгэлтэй гарсан. Цаашаа хил гарахдаа ингээд нүүрсгүй гээд гараад явсан байна гэдгийг л бид нар ингээж сонсголоор тогтоох ийм зорилго байсан юм.

Тийм учраас одоо боломжгүй байсан учраас энийг ингэж л ярихаас өөр арга байхгүй.

Ганбаатар гишүүн.

**С.Ганбаатар:** Энэ Монголчуудын хамгийн анхаарч байх ёстой асуудал. Энэ нэг хэдэн улс төрчид өөрсдийнхөө гэрт байгаа мөнгөн аягыг энэ тийшээ зарчихсан явдал биш. Монголын ард түмний баялгийг хулгайлчихсан. Тэгээд зүгээр нэг алтан гулдмайг кармалаад гарахыг ойлгоно. Энэ бол хулгайлж болно тэгээд аймшигтай хулгай байна л гэж бодно. Энэ чинь сая сая тонноор нь хулгай хийнэ гэдэг чинь Монголын шүүх, цагдаа, прокурор, АТГ хаана байсан юм бэ? Бид бол яг нарийн яривал ард түмний ард иргэдийн баялгийг хулгайлсан маш том баян улс төрчидтэй тэмцэж байгаа ажил Түр хороо шүү дээ. Эдний ард улс төрчид л байгаа. Шүүх цагдаа хүчний байгууллагуудтай нийлсэн хам хэрэгтнүүдтэй мафийн тогтолцоотой улс төрчидтэй тэмцэж байгаа.

Тийм ч учраас манай энэ Түр хороо байнгын дарамт бэрхшээл дундуур явж ирлээ. Замхруулах гэж байна шүү дээ цаана чинь. Зүгээр л замхруулах гэж байна. Тэгэхлээр би 2 зүйл хэлье.

Нэгдүгээрт энэ шүгэл үлээх ажиллагаа энэ аймшигтай олон сая тонноор нь нэг гар утас IPONE 13 хулгайлах гэхлээр л ер нь манай хүүхдүүд ер нь хорвоо дэлхий ч бодогдоод явчхаж байна шүү дээ. Тэгэхэд чинь энэ чинь сая сая IPONE хулгайлж байна шүү дээ. Аймшигтай том хулгай. Тэгээд анх энийг шүгэл үлээсэн хүн нь бол Адьшаа гишүүн үлээсэн. 2022 оны 6 сарын 2-нд Монгол Улсын Их Хурлын гишүүний энэ Ширнэнбандийн Адьшаа гээд бланкан дээрээ ингээд гишүүдээр гарын үсэг зуруулаад явж байсан. Тэгээд Ганболд гишүүнээр ахлуулаад явсан. Манай энэ Түр хороо 8 удаа хуралдсан. Би нэг ч хуралдаан таслаагүй. Манай энэ

шинжээчид Бат-Эрдэнэ, Адьяацэрэн, Батмөнх, Онгонцэцэг. Би нэр хэлээгүй зөндөө хүн байгаа шүү. Ажлын хэсэг байна. Тамгын газрын ажлын хэсгийнхэн. Бүүр өдөр шөнөгүй бид ажиллаж байсан. Тэгээд овоо гайгүй ажиллаад яг үр дүн гаргана даа. Баахан хулгай илрүүлээд үгүй Оюу Толгойн хулгай бол супер хулгай, супер луйвар. Энэ бол увайгүй, бүүр мэдлэггүй, арчаагүй хулгай. Энэ нүүрсний хулгай бол. Тэгээд илрүүлчээд яг эзэн биетэй нь хариуцлага тооцоод нүүрэлдүүлье гээд сонсгол хийгээд 4 сард бид нар хийхээр бүр бүх юмаа бэлдчихээд байсан. АТГ-аас бичиг ирсэн. Энэ Буянтүмэн гээд дарга эрхэлсэн комиссар Буянтүмэн гэж байна.

Ерөөсөө л хөндлөнгөөс битгий оролцоод бай. Нэр бүхий оролцогчдыг танай энэ цахимаар болон биеэр оролцох боломжгүй байна. Ажиллагаа дуустал ингээд хойшлуулах нь зүйтэй байна гэсэн. Одоо энэ Буянтүмэнд, АТГ-д Их Хурлаар хариуцлага тооцмоор байна. Одоо ингээд л бараг л Ганболд гишүүн бид нар ингээд татаад алга болгочихсон юм шиг. Үгүй шүү дээ. Үгүй яг бид нар чинь хулгайг барих гэж байхад энэ олон шинжээчдийн нойр хоолгүй хөдөлмөрийг ажил болгох гэж байхад ингээд татсан. Энэ бол 1 дүгээр асуулт.

Энэ Буянтүмэн АТГ-д хариуцлага тооцох уу? Эд нар үр дүнгээ гаргасан уу? Нөгөө энэ дотор бүр ярьж байна шүү дээ. Удаанжаргал, Ганхуяг гээд хулгайч нар энэ хүмүүс байна. Эд нарыг илрүүлэхэд битгий саад болооч дээ гэсэн. Илрүүлсэн үү? Одоо гудамд явж байгаа шүү дээ.

Энийг 1 дүгээрт даргын хувиар асуусан уу тодруулсан уу? Миний 1 дүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт. Бид төвлөрч ажилласан би өөрөө их идэвхтэй зүтгэж ажилласан ухаантай. Нууц гэрээг ил болгосон. Энэ Түр хороо. Нууц гэрээг ил болгоод ил болгосон гэрээнүүдийн

хэрэглэгчдийн хянан шалгах шинжлэх ажилд манай шинжээчид ажилласан. Зүгээр л амаар явсан. Оюутолгойгоос ч ач холбогдлоороо буурахааргүй тийм том хэлцлүүд зүгээр амаар явсан. Дохио зангаагаар явсан. Бөөн хулгай нүүрлэсэн гэсэн үг. Хуульгүй доор хулгай, мэдлэггүй доор боол. Тэгэхээр энэ дээр тэр Норинко, Чалкогийн гэрээг байнга ярьдаг. Нууцлалын гэрээнээс гаргачихвал бид торгуульд хүлээх гээд байна гээд олон улсын конвенц дээр нууцлал гэвэл патент.

**Г.Ганболд:** Ганбаатар гишүүний цагийг сунгая.

**С.Ганбаатар:** Нэгэнт бид нар дуустал нь үзнэ ээ. Норинко, Чалкотой холбоотой гэрээг ил болгоход бид торгуульд орох гээд байна гэж байна. Тийм юм байдаггүй юм. Эд нар зүгээр л хулгайгаа нуух гэж биднийг мангартуулж байгаа нь хэнд ч ойлгомжтой. Тэр дотор байгаа патент технологийн зориулалттай нууцлалын юм байгаа бол бид тэрийг үзэхгүй. Цэрэг дайны холбогдолтой янз бүрийн юм байвал бид үзэхгүй бусдыг нь ил болгох ёстой гэдэг шаардлагыг тавих боломж байна уу? Экспертүүдийн хувьд тавьсан уу? Миний 2 дугаар асуулт.

Миний 3 дугаар зүйл үндсэндээ ТЭЗҮ-ийг эд ерөөсөө тоогоогүй. ТЭЗҮ-ийг ерөөсөө авч хэлэлцээгүй. Яагаад энэ дээр ТЭЗҮ-ийг ингэж авч хэлэлцэхгүй байгаа тал дээр бид нар тэр холбогдох байгууллагуудаас нь асуух ёстой. Яагаад ТЭЗҮ гэдэг чинь хууль шүү дээ. ТЭЗҮ гэдэг чинь судлагдахуун байхгүй юу. Энэ тал дээр яг мэргэжлийн уул уурхайн тэр шинжээчдийн байгууллагууд, тэр мэргэшсэн зөвлөх байгууллагууд нь байгаа уул уурхайн хажууд Эрдэс баялгийн зөвлөл гэж байгаа. Тэд нараас тодруулж асуусан хуулийн тайлбаруудыг авсан зүйлүүд байгаа юу?

**Г.Ганболд:** Ер нь манай Уянгахийг шинжээч яг энэ нууцад авсан

талаар хууль эрх зүй талаас нь шинжээчийн дүгнэлт гаргасан. Тэгээд энэ дээр Уянгахыг шинжээч нэмж хариулна биз.

Бид нарын үзэж байгаагаар бол би энэ дүгнэлтүүддээ бүгдэд нь бичсэн байгаа. Ер нь энэ ажлууд дээр нууцад авах шаардлага байгаагүй гэж үзэж байгаа юм. Нууцад авахдаа үндэслэл болгосон заалтууд нь ч өөрөө эргэлзээтэй. Энэ өөрөө шинжлэх ухааны туршилт. Ийм зүйлүүдийг хийхэд л шаардлагатай байсан гэж ингэж үзэж байгаа юм л даа. Тэгээд энэ талаар манай Уянгахыг шинжээч дүгнэлт гаргасан хүний хувьд тэр яг нууцад авсан асуудлаар хариулт хэлэх байх гэж ингэж бодож байна.

АТГ-ын хувьд бол би нэг зүгээр яах вэ өмнө нь бас манай Ганибал гишүүн ч гэсэн хэвлэлээр ярьж байсан. Бид нар яг 4 сарын 10, 11, 12-ны өдрүүдэд сонсгол хийхээр төлөвлөөд сонсгол дээр дуудах гэрчүүдийнхээ нэрсийг эцэслэх байсан юм. Тэрийг манайхан бүгдээрээ мэдэж байгаа. Тэгээд энэ хүрээнд би АТГ-т ерөөсөө энэ нүүрсний хулгайтай холбоотой асуудлыг ярихын тулд Эрдэнэс Тавантолгой компанийн захирлаар ажиллаж байсан Ганхуяг мөн Монголын төмөр замын захирлаар ажиллаж байсан Удаанжаргал нарыг заавал оруулах шаардлагатай байна. Өмнөх Хяналтын ерөнхий сонсголын үеэр Удаанжаргал манай сонсголыг зохион байгуулах ажлын хэсэгтэй холбогдож цахимаар оролцъё гэдэг ийм хүсэлт тавьж байсан юм.

Дахиж ийм хүсэлт тавих юм бол оролцуулах боломж байгаа юу гэдэг агуулгаар АТГ руу бид нар албан бичгээр хандсан байсан. Энэ хүмүүсийг оролцуулж өгөөч гэж. Тэгээд тэр бичгийнхээ хариуг хүлээгээд одоо нөгөө нэрсээ зарлах эцэслэж зарлаж чадахгүй байсан учраас жаахан удсан. Энэний дагуу АТГ тэр хүмүүсийг оруулах боломжгүй. Дээр нь бол энэ мөрдөх

ажиллагаанд саад учруулна хойшлуулаач гэдэг ийм бичиг ирээд л бид нар хойшлуулсан юм.

Тэгэхээр зэрэг Ганбаатар гишүүний хэлж байгаа үнэн. Тэгэхээр бид нар бол одоо Түр хорооны зүгээс тайлангаа тавина. Гэхдээ Их Хурлын хувьд тэр мөрдөх байгууллагуудыг энэ ажлуудаа шуурхайлах дээр бол хяналт тавьж бас тодорхой хугацаагаар шахах нь зүйтэй. Ганбаатар гишүүн ч гэсэн гишүүний хувиар бид нар шахах боломжууд байгаа. Эдгээр хүмүүсийн хэрэг юу болж байна гэдэг дээр би Түр хорооны даргаар ажиллаж байсан хүний хувьд байнга энэ Авлигатай тэмцэх газар бусад мөрдөх байгууллагуудыг цаашид шахаж ажиллана гэж ингэж бодож байна. Түр хороо татан буугдсан ч гэсэн гишүүнийхээ хувиар.

Уянгахыг шинжээч хариулъя.

Ажлын хэсгийн 2 дугаар микрофоныг өгье.

**Г.Уянгахыг:** Түр хорооны гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Миний зүгээс нууцаас ил болгосон 9 гэрээн дээр байгуулагдсан хууль эрх зүйн үндэслэл дээр гарсан зөрчлийн талаар шинжилгээ хийж шинжээчийн дүгнэлт гаргасан байгаа.

Ганбаатар гишүүний асуусан 2 асуултын хувьд болохоор 1 дүгээрт Норинко болон Чалкогийн гэрээ тухайн нууцаас ил гаргасан гэрээний жагсаалтад байгаагүй учраас яг бидний хувьд нөгөө дүгнэлтийн бүтцэд ороогүй байгаа. Харин Эрдэнэс Тавантолгой компанийн зүгээс бол хэрэв олон нийтэд нээлттэй биш байгаа тохиолдолд гэрээг гаргаж өгөх боломжтой. Тэрэн дээр яг тусгайлан нөгөө нийтийн сонсголд оруулахгүйгээр шинжээч бол тайлбар хийх боломжтой гэдгээр бол гэрээг гаргаж өгч болно гэдэг тайлбарыг өгсөн.

Тэгээд хэрвээ шаардлага тухайн яг шинжээчийн дүгнэлтэд яг Норинко Чалкогийн гэрээний асуудал ороогүй. Шалтгаан нь юу вэ гэхээр яг нөгөө ажлын даалгавар маань нөгөө нууцаас ил болгосон 9 гэрээний хувьд нөгөө дүгнэлт гаргах гэсэн байсан учраас энэ 2 гэрээг оруулаагүй байгаа.

Цаашид энэ Норинкагийн 2 гэрээ болон Чалкогийн гэрээн дээр ажиллах боломж бий гэдэг тайлбар өгмөөр байна.

Хоёрдугаарт ТЭЗҮ-ийн хувьд болохоор Бат-Эрдэнэ шинжээч болон Даваасүрэн шинжээч яг санхүү талаасаа ТЭЗҮ дээр ажилласан. Тэгэхээр 2 шинжээчийн маань дүгнэлт дээр яаж тусгагдсаныг сайн мэдэхгүй байна. Миний зүгээс бол ТЭЗҮ-тэй холбоотой дүгнэлт бол гаргаагүй байгаа.

**Г.Ганболд:** ТЭЗҮ-тэй холбоотой бол Ганбаатар гишүүн ээ ийм л ноцтой юмнууд нь ийм л байгаа юм. Ерөөсөө энэ Зүүнбаян Гашиунсухайт чиглэлийн ТЭЗҮ-ийг одоогоороо Монгол хэл дээр хөрвүүлээгүй. Ерөөсөө англи хэл дээр л явж байгаа.

Тийм учраас нөгөө Монгол талын хяналт тавих Монголын төмөр зам юм уу Тавантолгой төмөр замын хүмүүс нь очоод ингээд нөгөө ТЭЗҮ-тэй танилцахтай зэрэг нууцад хамруулчихсан гэдэг байдлаараа нэг ёсондоо төр нууцад хамруулж байгаа шүү дээ. Гэтэл одоо нөгөө хувийн хэвшил нь нууцад хамруулчихсан юм шиг нөгөө төрийнхөндөө өгдөггүй ийм их ноцтой зөрчил илэрсэн юм. Очоод нөгөө Тавантолгой төмөр зам юм уу Монголын төмөр замын яг энэнд хяналт шалгалт хийх гэж байгаа хүмүүс нь өөрсдөө яг энэ төмөр зам дээр юу хийж байгаагаа мэддэггүй. Нөгөө хувийн хэвшлийнхнээс очоод материал авъя гэхээр нууц гээд өгдөггүй. Ийм их ноцтой зөрчлүүд байгаа юм. Тэгээд ТЭЗҮ ерөөсөө шинэчлээгүй. Зөвхөн одоо Айкомын Тээү дээр Домён гээд Солонгосын компаниар нэмэлт ТЭЗҮ

л гаргасан. Та бүхэн сая зүгээр ингээд анзаараад явах юм бол энэ дээр бол ноцтой юмнууд байгаа юм. Жишээлэх юм бол Домьёоны ТЭЗҮ дээр байна шүү дээ. Түрүүн хэлсэн шүү дээ 1300 айлын орон сууц барина гээд ТЭЗҮ нь тусгачихсан байхад 2 тал ярилцаад л 1300 айлын орон сууцыг нь больчихсон. Шууд нүүрс буулгах талбай болгоод л явчхаж байгаа байхгүй юу. Гэтэл өнөөдөр нөгөө төмөр зам маань цаана хил дээр холбогдоогүй байгаа шүү дээ. Наана нь тойрог замын нүүрс буулгах гээд л. Би түрүүн хэлсэн анх байгуулсан гэрээн дээр нэмэгдээд бараг 4 зуугаад сая долларын нэмэлт гэрээ хийгдчихсэн явж байгаа шүү дээ. Домэйны нэмэлттэй нэмээд түрүүн хэлсэн. Тойрог замын тэр талбай гээд 109.9 сая доллар гээд. Ийм их хэмжээний гэрээнүүд нэмэгдээд явахаас гадна ер нь бид нар энэ Зүүнбаян-Гашиунсухайт дээр жаахан ноцтой байгаа нь өөрсдөө хөрөнгө босгож хийнэ гэххээд нарийндаа Эрдэнэс Тавантолгой компаниас эхлээд 110 сая долларыг бэлнээр авсан. 90 сая долларын нүүрс урьдчилгаа болгож авсан. 200 сая доллар авсан, тэгсэн хэрнээ Чалко, Норинко 2-той адилхан бүх нүүрс дээрээ 13 хувийн хөнгөлөлт эдэлж байгаа.

Тэгэхээр бол үндсэндээ тэднийх чинь өөрөө зах зээл дээрээс мөнгө босгож бариагүй болчихож байгаа байхгүй юу. Уг нь энэ ТЭЗҮ яасан юм гэхээр зэрэг олон улсын зах зээл банк бус санхүүгийн байгууллагууд дээрээсээ мөнгө босгоно гэдэг агуулгаар ТЭЗҮ дотор нь зөвхөн хүүгийн зардал гэхэд 120 сая доллар байгаа шүү дээ. 120 сая доллар.

Гэтэл энийг ёстой нэг ёсондоо ашиглаагүй гэсэн үг болж байна шүү дээ. Тэгэнгүүт өөр ажил руу шилжүүлсэн. Шилжүүлсэн ажил нь бол яг тоо хэмжээгээрээ дөчхөн сая доллар. Тэгэхээр энэ дээр хөндлөнгийн шинжээч томилж ажиллуулах ийм зайлишгүй шаардлага байгаа юм. Манай шинжээчдийн дүгнэлтээр бол яг энэ

Зүүнбаян төмөр замтай холбоотой маш олон зүйлүүд байгаа. Та бүхэн наанаасаа дэлгэрэнгүй сайн унших юм бол олон заалтаар ийм тодорхой фактуудыг гаргаж тавьсан байх.

Ганбаатар гишүүн.

**С.Ганбаатар:** Миний санаа зовж байгаа зүйл гэвэл бид чинь 4 сард болох хэлэлцүүлгээр бол энэ нарийн ширийн бөөн юм болж би Даваасүрэн шинжээчээ бас хэлээгүй байна шүү. Тамгын газрынхан маань олуулаа байгаа. Бүгдээрээ ингээд оролцсон. Энэ олон хүний хөдөлмөрөөр бид бас ингээд нууцын түвшинд байж байгаад нөгөө гэрч нөгөө хулгай хийсэн байх магадлалтай хүмүүстэйгээ нүүрэлдэж уулзуулъя гэж энэ материалаа их дарж байлаа, хамгаалж байлаа. Яг л ард түмний төлөө шүү дээ энэ чинь. Бүгд ард түмэн чих тавин сонсож байгаа. Одоо нэгэнт энэ АТГ-ын бичиг болж бидэнд нөгөө ёстой нэг гай болоод ингээд бүх юмыг зогсоочээ гээд хэлчихсэнээс болж энэ материалуудаа бид ингээд ард түмэндээ тайлагнаж байна. Энэнээс болж бидний харин ёстой нөгөөдүүл чинь резиндэж балруулдаад хамаг хулгайгаа балруулах тийм хүндрэл гарах уу? 1 дүгээр зүйл. Тэгвэл АТГ хариуцлагаа үүрэх үү?

Хоёрдугаарт, үгүй энэ цагдаа хүчний байгууллагууд энэ дээр маш муу оролцсон. Үгүй энэ чинь сая тонн нүүрс хилээр гарч байхад тагнуул, цагдаа мэдэхгүй байвал үгүй тийм улсуудад татвар төлөх хэрэг юу байна. Жишээ нь нэг гар утас кармандаа хулгай хийж байгааг хүртэл барьдаг улсууд шүү дээ уг нь. Тэгэхлээр энэ харамсмаар энэ цагдаа хүчний байгууллагуудын энэ асуудлыг Их Хурал дээр ярьж болох уу? Энэ чинь сая сая тонноор нь улсаас нь хулгай хийчхээд хүүхдүүд сургууль 3 ээлжээр, 2 ээлжээр ч явж байгаа газрууд байгаа. Цэцэрлэг хангалтгүй, эмнэлэг хангалтгүй, ажлын байр байхгүй, үйлдвэр баригдахгүй байна. Тэтгэврээ нэмэх гэж бөөн юм болж

байхад тонн тонноор нь хулгай хийж байгаа, сая саяар нь хулгай хийж байгаа юман дээр энэ цагдаа, хүчний байгууллага дээр хариуцлага тооцох уу? Энэ асуудлыг Их Хурал дээр ярих уу? Яагаад энийг хэлж байна гэвэл гааль энэ манай дүгнэлтэд байгаа шүү дээ.

Гааль дотоод хяналт шалгалтаараа тэр Асралт даргын илтгэл дээр байгаа шүү дээ. Дотоод хяналт шалгалтаараа хулгай байна гээд илрүүлээд цагдаагийн байгууллагад бид тухайн хүчний байгууллагад мэдээлсэн. Бүгдийг нь дарж байсан 3 асуудал байгаа. Бүгдийг нь дарсан. Хэрэгсэхгүй болгосон. Одоо яагаад хэрэгсэхгүй болгосон юм бэ гээд бид энэ ажлын хэсэг дээр ярьж байгаад асуусан чинь өө уучлаарай нээрээ хэрэг байна шүү дээ гээд буцаагаад сэргээсэн. Үгүй энэ чинь тоглоом юм уу? Тэр хүмүүс чинь одоо тэр форм өмсөөд тэр том эрх ямба эдлээд бороохой зүүгээд явж байгаа. Тэр чинь маш том хариуцлага байхгүй юу. Үгүй энэ чинь тэртээ тэргүй мань мэтийг хар мянган чагнадаг, тагнадаг, зовоодог л биз. Яг энэ улсуудыг чинь шалгах ёстой шүү дээ. Энэ асуудлыг өнөөдөр Их Хурал дээр ярихгүй бол энэний ард тэнгэрийн хулгайч нар байгаа нь үнэн.

Дандаа том улс төрчид байгаа. Дандаа сайд дарга нар байсан улсууд байгаа одоо ч байгаа. Тэгэхээр энэ асуудал дээр бид том юмны өөдөөс явж байгаа эрсдэлтэй байж болно. Анхны садаанууд нь гарч ирсэн. Тэгэхээр энэ асуудал дээр энэ саад болсон хүмүүсийг Их Хурал дээр ярьж хариуцлага тооцож болох уу? Энэ саналыг би оруулах хэрэгтэй гэж үзэж байна.

**Г.Ганболд:** Ерөөсөө энэ хэрэг ерөөсөө одоо болтол даамжраад явсны хамгийн гол шалтгаан нь 2013 онд Гаалийн ерөнхий газар дотоод хяналт шалгалтаараа бол энэ томоохон ноцтой зөрчлийг илрүүлсэн. 3758 автомашинаар 379 мянган тонн нүүрс гаргасан байна

гэдгийг тухайн үед нь бол Хятадын гааль Монголд албан ёсоор мэдээлэл өгдөг байсан. Тэр 2 гаалийн мэдээллээр тулсан. Тэгээд хоосон гарсан нь тогтоогдоод эрүү үүсгэж өгөөч гэж тухайн үеийн гаалийн байгууллага, ЦЕГ-т өгөөд эрүүгийн хэрэг үүсээд явж байхад нь татвар нуун нуун дарагдуулсан хэрэг байна гэдэг агуулгаар зүйлчлэлийг нь өөрчлөөд ингээд хэрэгсэхгүй болгосноос хойш энэ олон хэргүүдийг ингэж хэрэгсэхгүй болгосноос хойш ер нь энэ хэрэг ингээд даамжирсан гэж ингэж үзэж байгаа.

Тэгэхээр зэрэг би одоо тайлан дээр та мэдэж байгаа бол ер нь энэ дүгнэлтдээ бичсэн. Тэр битгий хэл би Эдийн засгийн гэмт хэрэг мөрдөх хэлтсийн ахлах мөрдөн байцаагч цагдаагийн ахмад Наранхүү гэдэг хүний нэр заагаад ийм хэрэг үүсгээд тэгээд прокурор дээр хэрэгсэхгүй болгосон гэдгийг хүртэл заасан байгаа. Тэгээд энэ хүрээнд бол бид нар заавал энэ өмнөх хэргүүд зарим хэргүүд нь сэргэчихсэн байгаа ЦЕГ-т газар дээр нь. Тэгээд өмнө нь энэ тогтоогдсон хэргүүд дээр тодорхой буруутай этгээдүүдэд нь хариуцлага тооцож байж л энэ байдал гарна уу болохоос өмнөх хэргүүд нь ингээд нуун дарагдаад явах юм бол хэзээ ч энэ хэргүүд цаашидаа энэ нүүрсний хулгай арилна гэж хэлэхэд хэцүү байгаа юм.

Тэгэхээр энийг бол мэдээж Их Хурал дээр хөндөнө өө. Та бас Их Хурлын гишүүний хувиар энэ асуудлыг ярих боломжтой гэж ингэж бодож байна.

Наранбаатар гишүүн асууя.

**Н.Наранбаатар:** Тайланг сонслоо. Тайланд бас Эрдэнэс Тавантолгой компанийн худалдан авалттай холбоотой өндөр дүнтэй гэрээнүүд тэгээд зах зухаас нь л тусгасан байна гэж ойлгож байгаа. Цаана нь маш олон гэрээ байгаа. Ер нь энэ Эрдэнэс Тавантолгой ХК-ийн энэ гэрээнүүдийг

ямар журмаар байгуулах ёстой юм. Гүйцэтгэх захирлын эрх мэдэл нь ямар байх ёстой юм. Хэдий хэмжээний гэрээг бие дааж өөрөө байгуулах эрхтэй байдаг юм? Ер нь энэ том гэрээнүүдийг яаж байгуулах ёстой юм. Монгол шалгаруулалт хийж явах ёстой юу? ТУЗ ямар шийдвэр гаргаж энэ гэрээ байгуулахад оролцох ёстой вэ? 2010 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж олон гэрээнүүд байгуулагдсан гэж үзэж байгаа. Нүүрс борлуулалтын гэрээ, худалдан авалтын гэрээ, хөрс хуулалтын гэрээнүүдийг бүгдийг нь та бүхэн авч үзсэн үү? Тэр гэрээнүүдийн хамаарал бүхий этгээдүүд гэх юм уу, тэр гэрээнүүд хууль зөрчиж байгуулагдсан хэдэн гэрээ нь хууль зөрчиж байгуулагдсан юм бол? Тухайн үед ажиллаж байсан ТУЗ-ийн гишүүд буюу гүйцэтгэх удирдлагуудын хамаарал бүхий компани нь энэ дотор байгаа юу үгүй юу гээд нэг ийм гэрээтэй холбоотой зүйлүүдийг тодруулаад асуучихмаар байх юм.

Тэр хамаарлуудыг нь та бүхэн бас гаргаж үзсэн юм уу, үгүй юм уу? Ганхуяг дураараа гүйцэтгэх захирал нь гэрээ байгуулаад байсан юм уу. ТУЗ-өөрөө оруулаад юу аваад байсан юм уу? Зөвшөөрөл аваад ТУЗ-ийн тогтоолын дагуу байгуулсан юм уу? Нүүрсний гэрээ гэхэд 200, 300 л гэрээ байх ёстой. Хэд нь яг хууль зөрчигдөж байгуулагдсан гэрээ юм. Хэд нь хууль дүрэм журмынхаа дагуу байгуулагдсан гэрээ юм. Тэгээд аливаа нэгэн улс төрчийн буюу тэр ТУЗ-ийн хамаарал бүхий тийм ААН-үүд энэ их хэмжээний гэрээнүүдийг байгуулсан зүйлүүд энэ шалгалтын явцад тогтоогдсон уу гэсэн ийм зүйлүүд дээр нэг мэдээлэл өгөөдхөөч.

**Г.Ганболд:** Би түрүүн хэлсэн Эрдэнэс Тавантолгой компани дээр 2018 оноос хойш 665 зөвхөн дотоодын худалдан авагч тендер зарлаж 9.8 их наяд төгрөгийн худалдан авалт хийсэн. Эндээс бол энэ худалдан авалтууд бол төрийн болон орон нутгийн өмчийн

тухай хуулийн дагуу л явсан. Тэгээд энэ дээр шууд гэрээ хийсэн зүйлүүд нь би түрүүнд нь ноцтой зүйлүүд нь бол би хэлсэн шүү дээ. Хамгийн гол нь манайх бол хэрэвзээ төрийн нууцад авсан бол тусгай журам байхгүй. Ойлгомжгүй болгоод шууд гэрээ хийх юм уу, үнийн санал авах юм уу гэдэг нь ерөөсөө тодорхойгүй. Тэгэхээр зэрэг цаашидаа бид нар энэ хэрэв төрийн нууцлалд авсан бол ямар журмаар ямар худалдан авалтуудыг хийх вэ гэдгийг тодорхой болгож өгөхгүй бол гүйцэтгэх удирдлагаар ажиллаж байгаа энэ хүмүүсийг ч гэсэн өөрсдөө өнөөдөр ингээд шоронгийн хаалга татахад хүргэж байна шүү дээ. Ойлгомжгүй байдалд оруулаад ингээд орхичихоор зэрэг шууд худалдан авалт руу ер нь орсон.

Ер нь тэгэхээр зэрэг энэ худалдан авалт нүүрсний гэрээнүүдтэй холбоотой зүйлүүд дээр бид нар энэ шинжээчдийн дүгнэлтээр гарсан ноцтой гэж байгаа зарим худалдан авалтуудыг л оруулсан болохоос биш бүх худалдан авалтуудыг авна гэх юм бол өнгөрсөн хугацаанд нүүрсний бараг 3 мянга гаран гэрээ худалдан авалтын тийм хэмжээний гэрээнүүдийг маш том баг орж бүгдийг нь шалгахгүйгээр тийм дүгнэлт гаргах боломжгүй байсан.

Тэгэхээр бид нар үнийн дүн өндөр тэгээд бас энэ зарим нь шууд гэрээ гэдэг нь бол одоо энэ сүүлдээ ямар зүйл рүү орсон гэхээр зэрэг Засгийн газрын гаргасан тогтоолын дагуу Эрдэнэс Тавантолгой компани ерөөсөө ТЕГ газар руу энийг нууцад авч болох уу гээд л бичиг явуулна, хамаарах уу гээд. Тэгэнгүүт нь тагнуулаас наадах чинь хамаарна гэхээр нь шууд шууд гэрээ хийчихдэг. Тэгээд сүүлдээ ингээд ойлгомжгүй байдалд ороод ирэхээр Эрдэнэс Тавантолгой компани сүүл рүүгээ ер нь бол одоо нэг журамтай больё гээд тусгай журам гаргасан байгаа юм. Компани нь шүү дээ. Тэгээд энэ бол бид нарын гаргаж байгаа дүгнэлтэд бид нар ингээд цар тахал юм

уу гэнэтийн гамшиг гарсан үед нэг мөрддөг журамтай. Шууд тэр журам руугаа шилждэг. Тэгэхгүй бол ингээд ойлгомжгүй байдал цар тахлаас болоод энэ бөмбөлөг тээвэр тэр PCR шинжилгээ эд нар чинь бол тухайн байгууллагууд нь бараг ингээд л хуралдаж байгаа. Нэг ийм хэлбэр рүү орёе гээд явчихсан зүйл байгаа байхгүй юу. Тэгээд би сая таны асууж байгаа тэр орон нутгийн Тавантолгойтой холбоотой гэрээн дээр Өмнөговь аймгийн иргэдийн Хурлын Төлөөлөгчид тухайн үеийн удирдлагууд тэр Тавантолгой компанийн ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх удирдлага, эзэдтэй холбоотой маш олон гэрээ байгаа. Маш олон гэрээ.

Нүүрс худалдахтай холбоотой тэр олон гэрээнүүдийг жишээ дурдвал дурдаж болно. Уг нь бол бид нар энийг сонсголоор яг гэрээнүүдийг хамааралтай нь ингээд тогтоохоор төлөвлөсөн байсан юм. Бүх гэрээнүүдийг хамаарлыг нь. Тэгээд нэгэнт сонсгол хийх боломжгүй Тавантолгой компанийг яг ингээд шалгаж байгаа учраас бид нар боломжгүй юм байна гээд оруулахгүй байна. Тэрнээс яг энэ нөгөө Тавантолгой компани нь бас Их Хурлын гишүүдтэй холбоотой. Ингээд АТГ дээр том шалгалт явж байгаа учраас энэ нь бас тэр шалгалтад нь нөлөөлчих байх гэж бодоод бид нар оруулахгүй байгаа болохоос биш ер нь Тавантолгой дээр хийгдсэн гэрээнүүдийн дийлэнх нь жижиг Тавантолгойн хувьд шүү дээ. ТУЗ-ийн гишүүд аймгийн удирдлагуудын хамаарал бүхий хүүхдүүд охид хүүхдүүдийнхээ нэр дээр байгуулсан компаниудтай холбоотой тийм зүйлүүд олон байгаа.

**Г.Ганболд:** Ганибал гишүүн асууя. Саналаа хэлэх гишүүд нэрсээ өгье.

Ганбаатар гишүүнээр тасалж байна. Энхтүвшин гишүүн.

**Т.Энхтүвшин:** Энэ шинжээчийн гаргасан саналуудтай санал нэг байна. Тэгээд энэ саналуудыг жоохон тодорхой болгож бичих шаардлагатай юм болов уу

гэсэн ийм бодолтой байж байна. Ер нь 2017-гоос 2020 онд юу гэдэг юм ялангуяа Эрдэнэс Тавантолгой ямар PR хийж байсан бэ гэхээр төр сайн менежер юм. Төр ашигтай төрийн байгууллага ашигтай ажиллаж болдог юм гэдэг ийм менежер ийм юу гэдэг юм тархи угаалтыг маш их хийж байсан юм. Тэгээд эцэст нь юу гэдэг юм ингээд шалгаад үзэхээр маш их зөрчилтэй ийм л асуудал гарч байсан юм.

Тийм учраас цаашидаа юу гэдэг юм бид нар Эрдэнэс Тавантолго, жижиг Тавантолгойг олон нийтийн болгох хувьчлах ажлыг яаралтай хийх хэрэгтэй юм. Ингэж байж л энэ хулгай зэлгийнээс салахгүй бол цаашидаа ингээд төрийн өмчтэй байгаад байх юм бол хулгай зэлгийн асуудал байдгаараа л байгаад байна. Зарим манай Улсын Их Хурлын гишүүд юу гэхээр ингээд хэдхэн олигархи авах гээд байна. Хувьчлах юм бол хэдхэн хүний гарт очно гэдэг ийм асуудал ярьдаг л даа.

Тийм учраас энийг аль болохоор юу гэдэг юм дээд хязгаарыг нь тавьж өгөөд ингээд олон нийтийн юм болгох биржээр гаргах энэ асуудлыг л бид нар яаралтай хийх ёстой. Ингэж байж бид нар цаашидаа энэ хулгай зэлгийн асуудлаас сална. Тийм учраас энэ санал дээр би юу гэж хэлэх гээд байна гэхээр Эрдэнэс Монгол жижиг Тавантолгойн хувьчлалыг яаралтай явуулж олон нийтийн болгох ажлыг яаралтай зохион байгуул гэдгийг бүүр нэр усаар нь ингэж оруулж өгвөл яасан юм бэ гэдэг саналтай байж байгаа юм.

Хоёрдахь асуудал бол үнэхээр юу гэдэг юм гүйцэтгэлийн хяналт тавьж байсан төрийн захиргааны байгууллагууд бол энэ 2017-гоос 2020 онд маш муу ажилласан. Нөгөө төрийн өмчтэй Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хаана байна. Нөгөө Мэргэжлийн хяналтын уул уурхайн хяналтын алба хаачсан юм. Нөгөө гааль, бусад хяналтын байгууллагууд хаачсан юм.

Үнэхээр гүйцэтгэлийн хяналт муу тавьснаас болоод л ийм зөрчлүүд гарч байсан.

Тийм учраас гүйцэтгэлийн хяналтыг тавьж байгаа энэ төрийн захиргааны байгууллагуудыг цаашидаа хяналтыг тогтмолжуулах гүйцэтгэлийн хяналтыг тогтмолжуулах гэдэг байдлаар энийг оруулах хэрэгтэй. Энэ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Уул уурхайн яам гээд.

Гурав дахь асуудал бол одоо ажиллаж байгаа Эрдэнэс Монголын ТУЗ-д олон нийтийн төлөөллийг хангалттай хэмжээнд оруулах хэрэгтэй. Ерөөсөө олон нийтийн хяналт байхгүй. Нэг хэдэн дарга нар л ордог Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар ингээд нэг баахан дарга нар оруулаад ингээд төрийн байгууллага нь ТУЗ-өө бүрдүүлээд явснаас болоод л ийм асуудал гарч байгаа юм. Хэн нэгэн улс төрчийн үгэнд ордог, хэн нэгэн даргын үгэнд ордог ТУЗ нь. Тийм учраас энэ ТУЗ-д олон нийтийн төлөөллийг оруулах бүүр хувийг нь зааж өгөөд энэ цаашидын санал дээр нь оруулмаар байна. 49 хувьд нь олон нийтийн төлөөллийг Эрдэнэс Тавантолгойд оруулах зайлиггүй шаардлагатай гэдэг юмнуудыг л ийм 3 зүйлийг л одоо энэ санал дээр оруулах шаардлагатай байна л гэдгийг хэлмээр байна.

Нэгдүгээрт нь хувьчлалын асуудал. Хоёрт нь энэ ТУЗ-ийн асуудал.

Гуравт нь энэ гүйцэтгэлийн хяналт тавьж байсан төрийн захиргааны байгууллагуудыг яаралтай энэ дээр нэр зааж оруулмаар байна гэдэг ийм саналтай байна.

**Г.Ганболд:** Ганибал гишүүн санал хэлье.

**Н.Ганибал:** Ер нь тэгээд энэ нүүрсний асуудал, энэ хил, боомтын асуудал, энэ чөлөөт бүсийн асуудал бид



нар Монгол Улс яагаад хөгжихгүй байгаа юм, яагаад энэ тогтолцоо нь буруу байгаа юм. Бүх юмыг ил болгож байгаа ийм нэг асуудал байна л даа. Бид нарын явж байгаа зам буруу байна гэдгийг маш тодорхой зааж өгч байна. Тэгэхээр бид зайлиггүй зоригтой өөрчлөлтүүд хийх ёстой. Хамгийн гол асуудал бол түрүүн Энхтүвшин гишүүний хэлээд байгаа олон нийтийн хяналтад юмнуудаа аваачиж хаяна. Төрийн төрийн хяналтад гэдэг ойлголт буруу юм байна. Тө эдийн засагт оролцох энэ төрийн эрх мэдлийг хязгаарлах ёстой юм байна. Ингэж байж цаашаа явахгүй бол хувийнхныгаа дэмжиж, чөлөөт зах зээлийнхээ зарчмыг барьж байж бид нар явж байж өнөөдөр дэлхийн хэмжээнд олон улсын хэмжээнд бас энэ компаниудаа бий болгож итгэл найдвар дээр тогтсон ийм бизнесийн харилцаанд бид нар орох зайлиггүй шаардлагатай байна гэдгийг харуулж байна. Ер нь хэд хэдэн боомтын асуудлууд дээр уг нь ч энэ гаалийнхан бүгдийг нь цахимжуулаад л мэдээллийг ил тод болоод байгаа. Тэгээд л нэг ийм нэг талбай нүүрсний талбай гэдэг нэг ойлголт руу бүгдээрээ л орчихсон.

Ер нь энэ том том уул уурхайнууд нь нүүрсний ордууд дээр нь гүнийн гааль буюу гүнийн гааль шууд газар дээр нь ажиллуулах энэ боломжууд ер нь байдаггүй юм болов уу? Энийг хэдүүлээ бас санал болгох ёстой л байх л даа зүгээр зөвлөмжид нь. Яагаад заавал нэг дамжлага бааз байгаад байгаа юм? Тэр дамжлага бааз дээр нь баахан хүмүүс өрсөлддөг. Тэнд заавал зүгээр нэг тоолуур тавиад дундаас нь мөнгө авдаг энэ ажлыг л бид нар зогсоох боломж байгаа шүү дээ. Монгол Улсад нэг их ямар тийм тоологдохооргүй тийм олон уурхай байгаа биш. Эд нар дээр нь өөр өөрсдийнх нь гаалийнх нь хүмүүсийг нь тавиад хяналтын тэр боомт дээр нь тавиад ингээд явчих юм бол цаашилаад одоо хөрш Хятад улсаас БНХАУ-аас гаалийнх нь мэдээгээ улирал болгон түлгая гээд оруулаад ирсэн байна шүү дээ тийм үү? Ингээд явах юм бол энд

ямар нэгэн хулгай цаашид гарахгүй байх боломж бас байгаа. Тэгэхдээ энэ зөв үү буруу юу мэдэхгүй мэргээжлийн хүмүүс хэлэх байх.

Тэгэхээр ийм байдлаар хэдүүлээ асуудал нэлээн гүн гүнзгий саналуудыг нь тавихгүй бол өнөөдөр бид нар магадгүй нэг хэдэн БЭТ томилонгуутаа ажил сайжруулчихсан цаашаа явж байна гээд өнөөдрийн Засгийн газар маань өөрөө өөрийгөө хуураад яваад байгаа байхгүй юу. Нэгэнт л тогтолцоо нь өөрөө энд төр оролцоод ирэхээрээ тэнд хулгайч нар байдаг. Тэр хулгайг нь төрийн бүх л институтүүд бүх ажил юунууд дээрээ шат шатандаа энэ хулгайд оролцоод явдаг нь бас харагдлаа шүү дээ. Гааль, тээвэр, бүүр тагнуул орж ирж байх шиг байна. Ер нь тэгээд л хууль хяналтын байгууллагууд нь бүгд хариуцлагагүй ажиллаад энэ үр дүн өнөөдөр энд гарч ирээд байна л даа. Тэгэхээр энийг том тогтолцоо системийн хувьд өөрчлөх гээд хэтэрхий их ингээд нэг ингээд нийгэмд буруу гэдгийг нь ойлгуулчихаад хийхдээ юу ч хийхгүй байх нь тэгээд бид нар эргээд ард иргэддээ бас л муу ажиллаж байгаагаа л илэрхийлж харагдуулах байх гэж бодож байна. Тэгэхээр саяын оруулж ирж байгаа тийм Энхтүвшин гишүүний саналыг л олон нийтийн хяналтад оруулах, тэгээд олон улсын хөрөнгийн бирж рүү гаргах энэ нөхцөлийг бүрдүүлэх энэ ажиллагаанууд дээр нь бид бүхэн бас мэргээжлийн түвшин тэр зөвлөх үйлчилгээнүүдийг нь аваад ингээд хийх зайлиггүй шаардлагатай байна гэсэн саналтай байна.

**Г.Ганболд:** Ганбаатар гишүүн саналаа хэлье.

**С.Ганбаатар:** Би одоо үйлдвэрчний ерөнхийлөгч байхад 10-аад жилийн өмнө нэг нийтлэл бичиж байсан юм. Шууд заръя гэдэг гарчигтай. Өдрийн сонин дээр гарч байсан. Шууд заръя. Өөрөөр хэлбэл өнөөдөр Тавантолгой дээр хулгай нүүрлэчихсэн байна гэж хэлээд одоо энийг ерөөсөө бушуухан шиг

хувьчилъя. Баян хүмүүст нь өгье гээд явчихвал буруудчихна. Өмчлөл буруу байхгүй. Ард түмэн энийг 100 хувь өмчилж байна гэдэгт буруу байхгүй. Ганцхан менежментэд буруу байгаа. Энийг улс төрчид тавина гэдэг бол тэд шунахай увайгүй. Дараагийнхаа сонгуулиа л бодож байгаа. Тэгэхээр би бүүр тооцоо гаргаж байсан. Аргаа л барж байна шүү дээ. Аман дээр нь 70 доллароор зарж байгаа, зарж байсан. Одоо бүүр 100, 111, 120 гэж явж байгаа. 50 доллароор зүгээр зарахад газар доор нь зарахад аман дээр нь энийг зараад зөөгөөд аваад яв гээд зарахад 7 тэрбум тонн нөөц гэж бодоход 350 тэрбум долларын тухай ярьж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ брокерууд чинь 350 тэрбум долларыг идэж ууж байгаа байхгүй юу. 350-аар Монголчууд бүгд ажилтай болно. Бүгд сургуультай, цэцэрлэгтэй, эмнэлэгтэй болно. Бүх зам төмөр зам баригдана. Ийм том боломжийг хулгайлж байгаа хүмүүсийн хажууд бид дуугай байж болохгүй. Үр дүн гаргах ёстой, хариуцлага тооцох ёстой. Хойшид ийм муухай юмыг таслан зогсоох механизм бүрдүүлэх ёстой. 3 зорилго л байгаа. Хүний муу үзэх гээгүй.

Тэгэхээр миний санал би шууд заръя гэдэг нийтлэлээ нэг дахиад тавих юм байна даа л гэж бодож байна. Тийм хэмжээний чухал асуудал. Өөрөөр хэлбэл менежментээ эргэж харах цаг болсон. Өнөөдөр Ганхуягийг хэн тавьсан юм бүгд мэдэж байгаа. Өнөөдөр энэ цагдаагийн дарга, энэ олон шүүх, прокурор, энэ агентлаг хяналтын газрын дарга нарыг тавьдаг хүн эндээс хулгай хийсэн. Муур багш байхгүй юу. Муур багш энд байгаа. Тэгэхлээр хаалттай хуралдаан дээр би нэр устай нь ярьж байсан. Тэгээд өнөөдөр миний хэлэх санал бол 1 дүгээрт энэ асуудал дээр хяналтын тогтолцооны шинэ зарчимд оруулна.

Хоёрдугаарт тэр ард иргэдийн хувьцаа гээд зүгээр нэг шилний цаанаас чихэр долоолгож байгаа юм шиг ингэж хууралт хийхээ болиод, тэр эргэлтэд

ордог, ашгаа өгдөг, хяналтаа тавьдаг байх нээлттэй компани болох тал дээр яаралтай Их Хурлаар санал оруулах ёстой.

Гуравдугаарт өнөөдөр энэ брокерын системийг болиод хамаагүй менежментийг нь харин уралдуулж төр өөрөө менежментийг нь уралдуулж контрактаар өгч болно. Одоо та нар Чилийн Коделко гээд л магтан дуулаад л байдаг. 100 хувь төрийн өмчит. Ганцхан менежментийг нь олон нийтийн бүүр хяналттайгаар нээлттэйгээр хариуцлага тооцох бүүр үр дүнгээ тооцох байдлаар ТЭЗҮ-ийг нь тооцох байдлаар гэрээ хийж өгдөг. Ийм байдлаар ийм тогтолцооны өөрчлөлт орохгүй бол бид үр хүүхдийнхээ өмнө хараалгаж амьдрахаар ийм хэцүү байдалтай байгаа гэдгийг би хэлье.

Гуравдугаарт, эцсийн дүндээ олон сая тонн нүүрс ингээд гарчихлаа. Одоо бид ингээд шуугиад л нэг хэдэн хүнийг нэг хариуцлага тооцоод л нэг шоронд явуулсан болоод л. Нөгөөдүүл нь идсэн мөнгөнхийхөө зууны нэг хувийг ч үрэхгүй шүү дээ. Зүгээр эвтэйхэн зохицуулаад л гараад ирнэ. Тэгэхлээр энэ олон 100 сая тонн. Би тоо баримт яриад яах вэ? Бас зарим нь нууцын зэрэгтэй байх. Олон их наяд төгрөгийн хулгайг буцааж төлүүлэх ёстой шүү ард түмнийг хохирдоггүй болгох ёстой. Өнөөдөр энэ хулгай хийчихсэн улсууд чинь зүгээр л өө ялаа үүрчихсэн гээд л инээд алдаад гараад ирдэг юм байж болохгүй шүү гэдгийг л хэлмээр байна.

Дөрөвт нь, харамсмаар шүү. Тэр хүчний байгууллагууд даанч яав даа. Энэ дээр хариуцлага тооцох ёстой гэсэн ийм 4 саналыг хэлээд Их Хурал дээр болон манай энэ Түр хороо яаж ийж байгаад л хугацааг нь дуусгачих шиг боллоо. Одоо энэ АТГ-аас бичиг ирээд л яаж ийж аргалж байгаад л энэ том хулгайч нар чинь бяртай л даа. Тэгэхдээ бид тэднээс илүү бяртай. Бидэнд ард түмэн байгаа тэдэнд тамга тэмдэг байж болно. Тэгэхээр миний хэлэх гол санаа бол одоо

энэ шинжээчид одоо өнөөдөр энэ ажилласан энэ эрч хүч, энерги, дараагийн хугацаа сунгаад шинээр эхэлж байгаа түр хороонд зайлиггүй бүгдээрээ эрч хүчтэй орж ажиллана шүү гэдгийг бас би уриалмаар байна.

**Г.Ганболд:** Баярлалаа.

Өнөөдөр Түр хороон дээр би нэг ийм л зүйл хэлмээр байна л даа. Бид нар бол түр хороо жил орчим хугацаанд ажилласан. Тэгээд энд бол бид нартай хамтарч үнэхээр энэ улс эх орныхоо төлөө чин сэтгэлээсээ аль нэгэн талын эрх ашгийг хамгаалахгүй ажилласан шинжээчид хянан шалгагчдаа би талархал илэрхийлье гэж ингэж бодож байна. Үнэхээр мэргэжлийн байсан. Үнэхээр энд сэтгэл гаргаж олон хоног ажилласан. Харамсалтай нь энэ хүмүүсийн хөдөлмөр талаар болж сонсголоор нөгөө нотлох баримтаараа нөгөө хүмүүстэйгээ мэтгэлцэх тийм боломж бололцоо олдоогүйд их харамсаж байгаа.

Өнөөдөр жаахан ингээд 4 сарын 10-наас хойш Үндсэн хуулийн өөрчлөлт энээ тэрээ гэсээр байгаад бид нарын хугацаа дуусаж байна. Харамсалтай нь сонсгол хийх боломжгүй болж байна. Энэ тэгээд одоо бас энэ чуулганы төгсгөл дээр хүмүүс нэг баяр наадам гээд энийг сонирхохгүй болж эхэлж байх шиг байна. Би нэг ноцтой хэдэн зүйл ярьж гэж ингэж бодож байна. Энэ дотор нүүрсний бодит хулгай гээд Онгонцэцэг шинжээчийн гаргасан сүүлийн жилүүдийн 3.2 сая тонн нүүрсний зөрөөг бид нар нотлохын тулд зөвхөн 2 нүүрс ачиж буулгах талбай дээр гаалийн иж бүрэн шалгалт хийхэд 1.1 сая тонн нүүрс дутааж байгаа юм. 1.1 сая тонн нүүрс гэдэг ямар хэмжээний нүүрс гэдгийг бол бид нар бодох ёстой. Бусад талбайнуудаас нь 2 сая тонн нүүрс эх үүсвэргүй уурхайн амнаас алдагдсан байна гэсэн үг. Нафтын талбайд гэрээгээр буусан нүүрснээс илүү бүрдүүлэлт хийгээд 2 сая тонн нүүрс гараад явчихсан. Зөвхөн энэ

сүүлийн 4 жилийн зөрчил нь гэхэд 3 сая тонн нүүрсний зөрчил байна. Энийг бид нар сонсголоор гааль хил хамгаалах тэр нүүрсний нафтын хүмүүсийг авчирч сонсох байсан юм. Зөвхөн 2 гуравхан нафт дээр шүү. Энэ дээр хамгийн том ноцтой зүйл нь бол сүүлийн жилүүдэд бид нар 7 сая тонн нүүрсийг 9-18-хан доллароор зарсан байгаа юм.

Хятад Улс нүүрсийг 7 ангиллаар авч байна. Коксжих нүүрс хагас коксжих, эрчим хүчний исэлдсэн нүүрс гэх мэтчилнээр. Тэгэхэд манайх дөрөвхөн ангиллаар чанартай нүүрснүүдээ чанаргүй гаргах 7 сая тонн нүүрсийг 9-өөс арван наймхан доллароор гаргасан байгаа юм. Энэ бол би хамгийн том хулгай хамгийн ноцтой асуудал гэж үзэж байгаа юм.

Тэр агуулгаараа бид нар энэ шалгалтын явцад өмнө нь Тавантолгой компани дээр дүгнэчихсэн байсан нүүрсийг авчраад өөр лабораторид шинжлүүлэхэд зөрөө гарч байгаа юм. Нэг ёсондоо үнэтэй нүүрсийг эрчим хүчний нүүрс байна гэж ингэж явуулсан. Энэ болгон дээр зөвхөн нэг Хятадын компани өөрсдөө нүүрс ачиж буулгах гэж яг нафтийн гэж ярьж байгаа талбай байгуулчихсан. 520-оод машин тэр компанийн нэр дээр.

Тэгээд 2 Тавантолгойтой 4, 5 гэрээ байгуулчихсан. Өөрийнхөө гэрээгээр, өөрийнхөө машинаар, өөрсдийнхөө гаалийн талбайгаар дамжуулаад ингээд хоосон нүүрс гаргах ийм боломжууд нээгдсэн байгаа юм. Тэгэхээр энэ нүүрсний бодит хулгай дээр бид нар үнэхээр бас шахааж анхаарч ажиллахаас өөр арга байхгүй. Түр хороо шаардаж байж энэ нууцад авсан гэрээнүүдийг ил болгосон. Тэгээд ил болгоод л нийгэмд дугуйлчихсан. Манай шинжээч нар асар сайн ажилласан. Сая ярьсан тэр Чалко, Норикогийн гэрээнүүдийг манай шинжээчид өөрсдийнхөө хувиар манай Даваасүрэн шинжээчид орж үзсэн. Тэгэхдээ нэгэнт

нийгэмд ил болгож болохгүй учраас бид нар энийг ярих боломжгүй байгаа юм.

Эргээд Арбитрын шүүхээр явах юм бол бас нэг ТӨК-ийг өрөнд оруулчихвал эргээд тэр хариуцлагыг хэн хүлээх вэ гэдэг агуулгаар явж байгаа юм. Энэ дээр би зүгээр ингээд нууцад авах үндэслэл байгаагүй гэж бид нар дүгнэж байгаа шүү дээ. Шаардлага ч байгаагүй. Ер нь аж ахуйтай холбоотой. Зүүнбаян төмөр замыг бид нар нууцад авахдаа Монголын нийгэм юу гэж үзэж байсан гэхээр зэрэг Зэвсэгт хүчний цэргийн ангиуд барих гэж байгаа юм байна л гэж бид нар ойлгоод л тэгээд л бид нар нууцад авсан гэж ойлгож байсан бол Зүүнбаян төмөр замын нийт ажлын б гаранхан хувийг л зэвсэгт хүчин барьчихсан байгаа шүү дээ. Нийт ажлын 90 гаруй хувийг нь хувийн хэвшлийн бусад ААН-үүдээр шууд гэрээ хийх боломжийг л олгосон. Шууд гэрээ хийх боломжийг тендергүйгээр шууд гэрээ хийх ийм л боломж олгосон байгаа. Энэ Тавантолгой -Гашуун сухайт чиглэлийн төмөр зам дээр бол зөндөө ярих юмнууд байна. Энэ нь бол бид нар өмнө нь ярьж байсан тэр овоолсон шороо гэж ярьж байсан. 206 км-ийн овоолсон шороог 276.4 сая доллароор авсан. Энэ шороог үнэлж авахдаа зүгээр Грант Торнтон гээд компанийн зүгээр хүмүүстэй ярилцлага хийсэн дүгнэлтээр л шууд аудитын дүгнэлтээр шууд авчихсан. Тэр нь бол одоогийн ханшаар ярих юм бол их наяд гаран төгрөг.

206 км-ийг 1 их наядад хувааж үзэх юм бол тэр овоолсон 80 хувийн гүйцэтгэлтэй тэр шороог нь 1 км-ийг нь 5 тэрбум төгрөгөөр л худалдаж авсан гэсэн үг болж байгаа юм. Энэ нь өөрөө тухайн замыг өсгөх ийм үндэслэл болгосон. Тэгэхээр энэ дээр бол бүхэлдээ энэ төмөр замыг барихад 1 сая долларын зүгээр зөвлөх үйлчилгээ авч болно гэж заасан бол 11 сая долларын зөвлөх үйлчилгээ 736 сая төгрөгийн зөвлөх үйлчилгээг хуулийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ авна гэдэг байдлаар

компаниудтай гэрээ хийгээд л мөнгийг нь өгчихсөн. Тэгээд нөгөөдүүл нь буцаагаад тайлан ямар зөвлөх юуны зөвлөгөө өгсөн юм. Санхүүгийн зөвлөгөө өгсөн юм уу, хуулийн зөвлөгөө өгсөн юм уу тодорхойгүй. Энэ мөнгө угаалтын асар том хэл хэлбэр болсон. Ер нь бол сүүлийн жилүүдийн томоохон төслүүд дээр зөвлөх үйлчилгээний мөнгө гэдэг бол зөвхөн Монголд ч биш дэлхий нийтээрээ энэ дээр асар их ач холбогдол өгч байгаа зүйл байгаа юм.

Тэгээд энэнтэй холбоотой сонгон шалгаруулалт өөрөө их ойлгомжгүй болсон. Бодь компанитай аль 4 сард нууцад авахаас өмнө санамж бичиг байгуулчихсан байсан. Сонгон шалгаруулалтгүйгээр байгуулсан тухайн үед байгуулахад нь Бодь бол санхүүгийн чадавхгүй компани байсан. Хасах баланстай компани байхад асар том ашиг олох жилийн 140, 150 тэрбумын ашигтай тийм компани болтол нь санхүүгийн боломжийг олгосон. Би тэр ААН-ийг би буруутгаж байгаа юм биш. Тийм боломжийг ТӨК-ууд нь зүгээр олгочихсон байгаа. Шинжээчийн дүгнэлт дээр вагон дутуу, тэр вагон нь олон улсын зах зээл дээр борлуулагдаж байгаагүй нийт нүүрсээ бол 13 хувийн хөнгөлөлттэй өгсөн. Домэйн ТЭЗҮ-ээр тусгагдсан 1300 айлын суурьшлын бүсийн барилга барихыг нь өөр ажил руу 2 талын ингээд ярилцаж тохиролцооноор шилжүүлсэн гэх мэтчилнээр нэлээн ноцтой зүйлүүд олон байгаа юм. Тэгээд энэ болгоныг бид нар бас энэ нууц гээд байгаа гэрээнүүдтэй холбогдуулж бид нар цаашидаа одоо энэ Богд Хаан төмөр замын ажлыг явуулах юм уу, түр зогсоосон бол эсвэл шийдвэр гаргаад бүрэн зогсоох, бүрэн зогсоосон тохиолдолд өмнөх урьдчилгаа олгосон төлбөрүүдийг яаж барагдуулах юм гэх мэтчилнээр энэ нууц гэрээнүүдтэй холбоотой зүйлүүдийг бид нар ярихаас өөр аргагүй байна.

ТӨК-уудтай холбоотой энэ худалдан авалтуудыг ил тод болгох ТӨК-

уудыг ер нь бол олон нийтийн хяналтад оруулах тал дээр анхаарахгүй бол улсын төсвөөс давсан томоохон худалдан авалтуудыг хийдэг. Манай түр хорооны гишүүд сая ач холбогдол өгөхгүй байх шиг байна. Зөвхөн нэг компанитай хийж байгаа гэрээ нь л бараг 1 их наяд төгрөгийн манай улсын төсвийн хөрөнгө оруулалт 1-ээс 1.5 их наяд байгаа шүү дээ. Улсын төсвийн бүхэлдээ жилийн. Гэтэл ТӨК-ийн нэг худалдан авалтын гэрээ нь л тийм хэмжээний гэрээ хийсэн. Нөгөө оруулж ирсэн тоног төхөөрөмжийг нь хүлээж авах боломжгүй болчихсон ийм зүйлүүд байна. Зарим талаар хүний амь настай холбоотой том даацын дугуйнуудыг хажуу талын тодорхойлолтуудыг нь арилгаж нийлүүлдэг гэх мэтчилнээр энэ ТӨК-уудын энэ томоохон ноцтой зүйлүүд байгаа юм. Жижиг орон нутгийн Тавантолгойн хувьд бол ТҮЗ-ийн болон компанийн гүйцэтгэх удирдлагууд аймгийн иргэдийн Хурлын Төлөөлөгчдийн хамаарал бүхий маш олон компаниуд нь нүүрсний гэрээ худалдан авах гэрээ хийсэн. Энэ болгоныг бид нар энэ сонсголоороо илүү олон нийтийн өмнө гаргаж тавья гэж ингэж зорьж байсан боловч харамсалтай нь сонсгол хийгээгүй ээ.

Тэгэхээр энэ дээр бас манай Түр хорооны гишүүд маань энэ тайлан дээрээ саналуудаа хэлээд шинжээч хянан шалгахтайгаа нийлж маргааш Их Хурлын чуулган дээр тавих тайлангаа бас нэг ингэж зангидаж нэг хэлбэр рүү оруулж тавих нь зүйтэй байх гэж ингэж бодож байна.

Ингээд Түр хорооны явцын тайланг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Түр хорооны дарга миний бие танилцуулъя. Ингээд Хилийн боомтуудаар ачаа тээвэр, нүүрс тээвэрлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалган тогтоох хяналт шалгалт хийх үүрэг бүхий түр хорооны хуралдааны хэлэлцэх асуудлаа хэлэлцэж дууслаа.

Ингээд хурлын ажиллагаа хаасныг мэдэгдье ээ.

14.13 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА